МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“ЦАХИМ ОРЧИНД ХҮНИЙ НЭР ТӨР, АЛДАР ХҮНД, АЖИЛ ХЭРГИЙН НЭР ХҮНДИЙГ ХАМГААЛАХ ТҮҮНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД”

Судалгааны код: **БГСТ-25/001**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: Э.Туул

Улаанбаатар хот
2025 он

Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 3
Судалгааны үндэслэл, шаардлага 4
Судалгааны арга, хамрах хүрээ 4
Судалгааны бүтэц 5

НЭГ. ХҮНИЙ НЭР ТӨР, АЛДАР ХҮНД, АЖИЛ ХЭРГИЙН НЭР ХҮНДИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ: 6
1.1. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн тухай 6
1.2. Эрүүгийн хууль дахь зохицуулалт 7
1.3. Иргэний хууль дахь зохицуулалт 7

ХОЁР. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ, ТҮҮНИЙГ ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ 11
3.1. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийн баталгаа: 11
3.2. Цахим орчин дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээ ... 14
3.3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 19

ГУРАВ.ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА 25
3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс 25
3.2. Оросын холбооны улс 26
3.3. Бүгд Найрамдах Эстони Улс 27
3.4. Бүгд Найрамдах Өмнөд Солонгос Улс 29
3.5. Европын Холбоо 30

ДҮГНЭЛТ 32

САНАЛ ЗӨВЛӨМЖ 35

НОМ ЗҮЙ 36

ХАВСРАЛТ 38
№1 ИРГЭН “Н”-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААСАН” ГЭМТ ХЭРЭГ 38
№2 ИРГЭН “Б.Э”-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААСАН” ГЭМТ ХЭРЭГ 40
№3 ИРГЭН Ц-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ 42
№4 ИРГЭН “Ц.С”ИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ 44
№5 ИРГЭН “С.М”ИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ 46
№1 ЭДИЙН БУС ГЭМ ХОРИГ АРИЛГАХ /НЭР ТӨР, АЛДАР ХҮНД, АЖИЛ ХЭРГИЙН НЭР ХҮНДИЙГ ГУТААСАН/ 48
№2 ЭДИЙН БУС ГЭМ ХОРИГ АРИЛГАХ /НЭР ТӨР, АЛДАР ХҮНД, АЖИЛ ХЭРГИЙН НЭР ХҮНДИЙГ ГУТААСАН/ 49

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНЭУ	Бүгд Найрамдах Эстони улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард улс
ИБУТЭОП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
ХХЗХ	Харилцаа Холбооны зохицуулах хороо
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ОХУ	Оросын Холбооны Улс
УИХ	Улсын Их Хурал
ЕХ	Европын Холбоо

Хүснэгт 1 Үзэл бодлоо цахимаар илэрхийлэх хэлбэр 12
Хүснэгт 2 Эрүүгийн шүүхийн шийдвэрийн тоон мэдээлэл..... 19
Хүснэгт 3 Иргэний шүүхийн шийдвэрийн тоон мэдээлэл 23

Удиртгал

Судалгааны үндэслэл, шаардлага

Иргэдийн мэдээлэл авдаг гол эх сурвалж нь радио, телевиз, сонин, сэтгүүл байсан бол технологийн хөгжлийн үр дүнд цахим орчноос мэдээлэл авах нь давамгайлах болсон. Цахим орчин нь иргэдийн өдөр тутмын хэрэглээ болж, интернет хэрэгслийг мэдээллийн эх сурвалж болгон олон нийтийн сүлжээ ашиглаж үзэл бодлоо илэрхийлэх, аливаа зүйлийг нийтлэх болсон. Дэлхийн дахинд интернэт хэрэглэгчдийн тоо 2024 оны байдлаар 5,4 тэрбум буюу дэлхийн нийт хүн амын 67.1 хувийг[1] харин Монгол Улсын хувьд 2,91 сая нийт хүн амын 72 хувьтай тэнцэж байна.[2] Үүнээс үзвэл цахим орчин нийгмийн харилцаанд маш өргөн хүрээг хамарч байгааг илтгэж байна. Эерэг тал нь мэдээллийг түргэн шуурхай авч байгаа бол сөрөг тал нь хуурамч мэдээлэл авах, төөрөгдөлд орох эрсдэлийг дагуулж байна.

НҮБ-аас цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх нь уламжлалт хэвлэл мэдээллээр үзэл бодлоо илэрхийлэх эрхийн адил олон улсын гэрээ конвенцоор хамгаалагдахыг онцолсон байдаг. Цахим орчин буюу олон нийтийн сүлжээ нь гэмт хэрэг үйлдэг нэг арга хэлбэр болж байна /кибер аюулгүй байдал буюу халдлага, вируст өртөх, хувийн мэдээлэл алдах, хуурамч мэдээл тараах, цахим луйвар гэх мэт/. Монгол Улсын иргэдийн хувьд мэдээлэлд шүүлтүүртэй хандах хандлага нь сул байгаа бөгөөд мэдээллийн үнэн зөв гэдгийг нягталж чадаж байгааг эсэх, хүлээн авч байгаа мэдээлэлдээ хир шүүлтүүртэй, хандаж байгаа нь өнөө цагийн тулгамдсан асуудал болж байна.

Энэхүү судалгаагаар цахим орчинд хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах арга хэмжээний талаарх эрх зүйн зохицуулалт, иргэдийн мэдээлэл хүлээн авах, хүлээн авч буй мэдээ, мэдээллийн үнэн бодит байдалд шүүлтүүртэй хандаж буй эсэх, мэдээллийн эх сурвалжийг нягтлан шалгаж буй байдал, олон улсын жишиг, гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалт туршлагыг судалж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр үндэслэл бүхий санал, зөвлөмж боловсруулахыг зорилоо.

Судалгааны арга, хамрах хүрээ

Энэхүү судалгаагаар “цахим орчинд хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдах”-тай холбогдох олон улсын эрх зүйн зохицуулалт болон үндэсний хууль тогтоомж нь олон улсын гэрээ, конвецид нийцэж буй эсэх, зарим улс орны хууль тогтоомжийг харьцуулан судлах бөгөөд Эрүүгийн хууль болон Иргэний хуульд заасан хариуцлагын зохицуулалтыг судлан авч үзэх болно. Уг судалгааг хууль зүйн шинжлэх ухааны судалгааны гол арга болох

[1] Statista, Number of internet and social media users worldwide as of April 2024 https://www.statista.com/statistics/617136/digital-population-worldwide/. Сүүлд хандсан огноо: 2024.12.15

[2] https://datareportal.com/reports/digital-2024-mongolia

баримтын судалгааны арга, харьцуулсан судалгааны арга, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлалыг ашиглан гүйцэтгэх болно.

Уг судалгааны хамрах хүрээг олон нийтийн цахим сүлжээ /facebook, twitter, instragram, threads гэх мэт/-г ашиглаж хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдаж худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэн доромжлох, асуудлаар хязгаарласан болно.

Судалгааны бүтэц

Энэхүү судалгааг гурван үндсэн бүлгийн хүрээнд гүйцэтгэлээ.

НЭГ. ХҮНИЙ НЭР ТӨР, АЛДАР ХҮНД, АЖИЛ ХЭРГИЙН НЭР ХҮНДИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ:

1.1. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн тухай

Хүний нэр төр, алдар хүндийг хамгаалж хүндлэх нь нийгмийн бүлэг, хувь хүн болон иргэн, төр хоорондын харилцан хүлээсэн үүрэг хариуцлага, эрх, эрх чөлөөний зарчим, ёс суртахууны болон эрх зүйн хэм хэмжээнд үндэслэсэн шинж чанартай байдаг. Эрх зүйт нийгэмд хувь хүн, иргэний хууль ёсны эрх ашиг, эрх, эрх чөлөөг төр хамгаалдаг. Иргэний нэр төр, алдар хүнд бол ардчилал, эрх зүйн хувьд манай улсад ч биеллээ олжээ.Түүний нэг илрэл нь Үндсэн хуульд баталгаажуулсан заалтууд юм. [3]

Тухайлбал, “Хүн бүр өөрийн нэр төр, алдар хүндийг хамгаалуулах эрх”-тэй болохыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тунхаглаж өгсөн бол түүнийг үндэсний хууль тогтоомжид улам тодотгож “Хэний ч нэр төрийг гутаан доромжилж болохгүй” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт заажээ. Иймхүү хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг дэлхий дахинд болон бүс нутгийн хэмжээнд олон улсын конвецоор, улс орнууд дотооддоо Үндсэн хууль түүнд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудаар баталгаажуулж байна.

Нэр төр нь тухайн хувь хүн нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээг биелүүлсний үр дүнд нийгмийн зүгээс түүнийг хүндлэх, хүлээн зөвшөөрөх хэмжээг тодорхойлдог бол, алдар хүнд нь аливаа хүн бүр энэхүү хүлээн зөвшөөрөлт, хүндлэлийг олж авах тэгш боломжийг хэлдэг.[4] Харин хүний алдар хүндийг зөвхөн Үндсэн хуулийн субьектив эрхүүдийн нэг обьект гэж үзэх нь учир дутагдалтай байна. Хүний алдар хүнд гэдэг бол гүн ухаан шашны сэтгэлгээгээр дамжиж дараа нь төр эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдөж хүмүүнлэгийн бүх ухаан, дийлэнхдээ эрх зүй судлалын тулгуур ойлголт болдог.[5]

Алдар хүнд, нэр төрийн эрх нь нэг талаасаа нийт хүн төрөлхтний үнэт зүйл, нөгөө талаас хүний үндсэн эрхүүдийн нэг юм. Түүнийг хамгаалах нь хоёр талтай.

1. Төрийн зүгээс нэр төр, алдар хүндэд халдахаас хамгаалах;
2. Хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах нь нийгмийн6
3. зүгээс бие хүний алдар хүндийг зөрчсөн тохиолдолд төр оролцох[6];

Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж

[3] ОХУ-н судлаач эрдэмтэн С.В.Михайлович “Условия, способы гражданско правовой зашиты чести, достоинства и деловой репутаци” бүтээл 2006 он 3 тал
[4] Шинжлэх Ухааны Академийн Мэдээ 2010 оны №03 (197) 47 тал
[5] Мөн тэнд
[6] Мөн тэнд

төрийн үүргийг хуульчилсан.

Хүн сайн сайхан амьдрах гол нөхцөл нь эрх, эрх чөлөөг баталгаажуулж, тэдгээрийг эрх зүйн арга хэрэгслээр найдвартай хамгаалах явдал юм.

1.2. Эрүүгийн хууль дахь зохицуулалт

2015 онд батлагдаж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-д Арван гуравдугаар бүлэгт хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийг хуульчлан зохицуулжээ. 13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шинээр хуульчлан нэмэлтийг 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдөр оруулжээ. [7]

Хуулийн тус заалттай холбоотойгоор иргэн Ж.Баттуул нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээлэл олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16,17 дахь заалтын зарим хэсгийг тус тус зөрчсөн тул хянан хэлэлцэж өгнө гэсэн агуулга бүхий мэдээллийг гаргасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2024 оны 08-р сарын 01-ны өдөр “Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай” дугаар 98 тогтоол гаргажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан 2024 оны 12-р сарын 06-ны өдөр товлогдсон боловч маргааны асуудлаар тодруулга тайлбар авах зэргээр тодорхойгүй хугацаагаар хойшилсон байна.

Түүнчлэн хуулийн тус зүйл заалттай холбоотойгоор хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүл зүйн салбарынхан, иргэд олон нийт, судлаачид нэлээдгүй шүүмжлэлтэй хандаж өөр өөрийн байр суурийг илэрхийлж, олон улсын гэрээ конвенцид нийцэхгүй талаар судалгаанууд гарч байна. Хамгийн сүүлийн үеийн мэдээллээр 2024 оны 12- р сарын 27-ны өдөр Улсын Их хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, Б.Баярбаатар, Д.Энхтуяа А.Ганбаатар нар нь хуулийн холбогдох заалтыг Эрүүгийн хуулиас хасах тухай хуулийн төслийг өргөн барьсан байна.

1.3. Иргэний хууль дахь зохицуулалт

Монгол Улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ” гэж заасан. Энэ зүйлд заасан эрхийг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг хохирогч буюу сонирхогч этгээдэд энэ хуулийн 497.1.Бусдын эрх, амь

[7] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020.02.13, №07 (1109), http://parliament.mn/n/wzmy

нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй. Хуулийн 511.1.Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлбэл "Бусдын нэр төр, алдар хүнд, нийгэмд эзлэх байр сууринд сөргөөр нөлөөлөх мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.

Улсын Дээд Шүүхийн 2007 оны 40 дүгээр тогтоолд "...нэр төр" гэж тухайн хүний хувийн болон ёс зүй, түүнчлэн ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшингийн талаар бусдаас өгч буй үнэлэмжийг, "...алдар хүнд..." гэдэгт бусдаас өөрийнх нь талаар өгсөн үнэлгээнд тулгуурлан өөртөө өгсөн тухайн хүний үнэлэмжийг ойлгоно. Харин "ажил хэргийн нэр хүнд" гэдэг нь зах зээлийн харилцаанд оролцогч хувь хүн, хуулийн этгээдад хамааралтай ойлголт бөгөөд тухайн этгээд ажил мэргэжлийн болон албан тушаалын үүрэгтээ шударга хандаж, түүнийгээ хэрэгжүүлж байвал ажил хэргийн нэр хүнд нь тогтвортой байдаг." [8]гэж тайлбарласан байна.

Зөрчлийн тухай хууль дахь зохицуулалт [9]

Зөрчлийн тухай хуулиар

- "Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн" [10]
- **"**Иргэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, хуулийн этгээд нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед олон нийтийг төөрөгдүүлсэн, худал мэдээлэл тараасан" [11]
- "Агаар бохирдуулсны талаар худал мэдээлэл өгсөн"[12]
- **"**Ус бохирдуулагчийн тухай болон хаягдал усны хэмжээ, найрлага, бохирдуулах бодисын тухай мэдээллийг нуун дарагдуулсан, эсхүл худал мэдээлэл өгсөн" [13]
- **"**Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс хэрэглэгчид бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой худал мэдээлэл өгсний улмаас хэрэглэгчийн эрх ашигт хохирол учирсан" [14]

[8] Иргэний хуулийн тайлбар УБ., 2010 он 37 дахь тал
[9] https://legalinfo.mn/mn/detail/12695
[10] Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих
[11] Зөрчлийн тухай хуулийн 6.31 дүгээр зүйл.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль зөрчих
[12] Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл.Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль зөрчих
[13] Зөрчлийн тухай хуулийн 7.16 дугаар зүйл.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих
[14] Зөрчлийн тухай хуулийн 10.2 дугаар зүйл.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль зөрчих

- “Монголбанкны хяналт шалгалтын тайлангаар банкны санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн, эсхүл банкны үйлчилгээ авахдаа санхүүгийн давуу эрх эдэлсэн нь тогтоогдсон хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлсөн, эсхүл даатгалын нөхөн төлбөр олгох банкинд зориудаар худал мэдээлэл өгсөн, [15]
- Даатгалын нөхөн төлбөр олгоогүй, эсхүл хуульд заасны дагуу олгох даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг зориудаар буруу тооцсон эсхүл худал мэдээлэл өгсөн
- Банк нь даатгалын тохиолдол бий болоход хуульд заасны дагуу хадгаламжийн даатгалд хамаарахгүй хадгаламж эзэмшигч этгээдэд даатгалын нөхөн төлбөр төлсөн бол зориудаар худал мэдээлэл өгсөн,
- Цөмийн энерги, цацраг идэвхит ашигт малтмалын талаар шаардлагатай мэдээ, тайлан гаргаж өгөөгүй, эсхүл худал мэдээлэл гаргаж өгсөн
- Үрийг худалдах, тээвэрлэхдээ түүний сав, баглаа боодлын шошго, дагалдах бичиг баримтад тухайн үрийн сортын нэр, гарал үүсэл, чанар, ариутгалын талаар болон хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, тухайн үрийг ашиглахдаа баримтлах дарааллыг харуулсан зөвлөмж, сортын бүтээгчийн эрхээр хамгаалагдсан эсэх талаар мэдээлээгүй, эсхүл худал мэдээлсэн
- Төрийн албан хаагч, эсхүл улсын байцаагчийн хууль ёсны дагуу шаардсан холбогдох мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл санаатайгаар худал мэдээлэл өгсөн, эсхүл төөрөгдүүлсэн[16]
- Тагнуулын байгууллагад санаатайгаар худал мэдээлэл өгсөн, төөрөгдүүлсэн[17]
- Монгол Улсын Засгийн газрын албан ёсны нэр, бэлгэдлийг хэрэглэж худал мэдээлэл тараасан[18]
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан болон Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаан, сонсголд оролцсон этгээд дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн [19]

Монгол Улсын хувьд хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын хувьд Монгол Улсын Үндсэн хууль Эрүүгийн хууль, Иргэний хуульд зохицуулсан байна. Зөрчлийн тухай хуулиар иргэн,

[15] Зөрчлийн тухай хуулийн 11.12 дугаар зүйл.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль зөрчих
[16] Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах
[17] Зөрчлийн тухай хуулийн 15.13 дугаар зүйл.Тагнуулын байгууллагын хууль ёсны шаардлагыг үлбиелүүлэх, үйл ажиллагаанд саад учруулах, оролцох, нөлөөлөх
[18] Зөрчлийн тухай хуулийн 15.31 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хууль зөрчих
[19] Зөрчлийн тухай хуулийн 15.33 дугаар зүйл.Парламентыг үл хүндэтгэх

хуулийн этгээд, албан тушаалтан нийгмийн эрүүл, нийтийн ашиг сонирхлыг хөндөхүйц худал мэдээ, мэдээлэл тараасан болон хуулийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна. Олон нийтийн сүлжээнд нэг л удаа сөрөг мэдээлэл нийтлэгдсэнээр мэдээллийн эзний амьдралд шууд сөрөг нөлөөллийг үзүүлдэг. Сэтгэлзүйн дарамтад орох, өөрийгөө эрсдэлд оруулах, нийгмээс тусгаарлагдах, ажил мэргэжлийн хувьд уналтад орох гэх мэт цахим хүчирхийлэлд өртдөг бөгөөд иргэд олон нийтийг төөрөгдүүлэх, нийгэмд эмх замбараагүй байдал хүргэх сөрөг нөлөөтэй юм.

Түүнчлэн иргэдийн олон нийтийн сүлжээ болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн ялгааг мэдэхгүй аль нь албан ёсны редакцтай, мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг вэ, аль нь нийгмийн сүлжээнд янз бүрийн нэрээр пэйж буюу хуудас үүсгээд өөрийгөө хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж хүмүүст ойлгуулан цаг үеийн шинжтэй мэдээллүүдийг ямар нэгэн шүүлтүүргүйгээр, баримтыг шалгахгүйгээр, эх сурвалжийг шалгахгүйгээр мэдээлэл тарааж байгааг ялгаж салгаж сурах, шүүлтүүртэй хандаж сурах хэвлэл мэдээллийн боловсролтой байх шаардлага зүй ёсоор гарч байна.

Учир нь цахим орчин буюу олон нийтийн сүлжээ нь гэмт хэрэг үйлдэх нэг арга хэлбэр болж байгаатай холбоотой бөгөөд хэзээ ч арлашгүй түүхийг архивыг үүсгэн хадгалж байдгаараа онцлогтой юм. Жишээ нь нэгэнт орсон худал мэдээллийг устгуулсан ч дахин өөр сурвалжаас нийтлэгдэх, шинэ цахим хуудсаар тараах, нийтэлсэн үед нь иргэд олон нийт өөрийн ухаалаг технологид хадгалж авах, цааш нь дамжуулах, хуваалцах эрсдэлтэй яг л фэйбүүкэд нэг пост нийтэлж олон мянган хүн шэйр хийж хуваалцаж, скрэйн шот хийж хадгалж авах, чат мессеж, дотоод сүлжээгээр дамлан түгээх боломжтой байдгаараа цахим орчин буюу олон нийтийн сүлжээ бодит нөхцөл байдлаас өөр юм.

ХОЁР. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ, ТҮҮНИЙГ ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийн баталгаа:

Монгол Улс үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протоколд нэгдэн орж, зохих үүрэг хүлээсэн байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй” энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” гэж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт-н 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй”, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэж заасан байдаг.

Монгол Улсад үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрхийг баталгаажуулсан голлох хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4-т “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй”, 14.3 дугаар зүйл “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” нь гэмт хэрэг байхаар зохицуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван Зургадугаар зүйлийн 16 дахь хэсэг болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1 болон 2 зүйл нь хүний үзэл бодлоо ирэлхийлэх эрхийг хамгаалсан байна.

Олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, улс орнуудын Үндсэн хуульд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан зүйл, заалтад “цахим орчин” гэх нэр томьёо тусгагдаагүй боловч үзэл бодлыг хэрхэн түгээж буй арга, хэлбэрээс үл хамааран уламжлалт хэлбэрээр илэрхийлж буйтай ижил түвшинд хамгаалагдах юм.

Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь аль ч нийгэмд суурь шинжтэй бөгөөд чөлөөт, ардчилсан нийгмийн тулгын чулуу юм.[20] Үзэл бодол илэрхийлэх, түгээх бүх төрлийн арга хэлбэр, арга хэрэгсэл бүгд хамгаалагдана. Тодруулбал илэрхийлэх арга хэрэгсэлд нь ном, сонин, тараах материал, дэлгэмэл хуудас, баннер,төрийн эрх бүхий байгууллагад гаргасан хууль зүйн шинжтэй өргөдөл, мэдээлэл, бүх төрлийн дуу дүрсний, цахим болон интернэтэд суурилсан үзэл бодол зэрэг нь хамаарна.[21]

[20] Benhadj v. Algeria, 1173/2003 дугаартай гомдолд холбогдох 2007 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дүгнэлтийг үзнэ үү. Park v. Republic of Korea, No. 628/1995 дугаартай гомдолд холбогдох 1996 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн дүгнэлтийг үзнэ үү.

[21] НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар (№34, §19, 2011): Үзэл бодолтой байх, үзэл бодлоо

Цахим сүлжээ бий болж хөгжсөнөөр нийгмийн харилцааны шинэ орчин гэж хэлж болох “цахим орчинг” бий болгосон. Цахим орчинг тодорхойлсон бүх нийтэд хүлээн зөвшөөрсөн нэгдсэн тодорхойлолт одоогоор байхгүй. Цахим орчинг /cyberspace/ интернет, харилцаа холбооны сүлжээ, компьютерын сүлжээ, процессор зэрэг мэдээллийн технологийн харилцан хамааралтай дэд бүтцийн сүлжээнээс бүрдэх дэлхийн нийтийн орон зай гэж ойлгодог.[22] Энэ нь хүн төрөлхтний мэдлэг мэдээлэл харилцан солилцох хэрэгцээнээс үүдэлтэй харилцан холбогдсон компьютеруудын сүлжээ ба энэхүү сүлжээ нь дэлхий дахиныг холбож байна.

Калифорни-Сан Диегогийн их сургуулийн эрдэмтдийн хийсэн судалгаагаар хүн өдөр бүр 34 GB-тай дүйх хэмжээний мэдээ, мэдээлэл дунд хөвөрдөг. Энэ нь зөөврийн компьютерийг долоохон хоногийн дотор хэт ачааллуулах хэмжээ хэмээн тогтоожээ. Мөн хүн өдөрт (сэрүүн байх 12 цагт) дунджаар 105,000 үг, секундэд 23 үгийг утас, интернет, цахим шуудан, телевиз, радио, сонин, ном зэргээр дамжуулж хүлээн авдаг байна. Хэдийгээр хүн өдөрт 105,000 үг уншиж чадахгүй ч, энэ нь өдөр бүр хүний нүд, чихээр дамжин хүрч болох тоо юм. Харин зураг, бичлэг, тоглоом зэргийг нэмснээр хүн өдөрт дунджаар 34 GB мэдээлэл хүлээж авдаг байна.

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэхдээ төрөл бүрийн платформыг тус бүрийн зориулалт, функцээс хамааран, өөр өөрийн хэрэгцээ, сонирхол, харилцааны хэв маягт нийцүүлэн тохирох хэлбэрүүдийг сонгон ашиглаж байна.[23]

Хүснэгт 1 Үзэл бодлоо цахимаар илэрхийлэх хэлбэр

Хэлбэрийн нэршил	Илэрхийлэгдэж буй хэлбэр	Платформ, төрөл
Нийгмийн сүлжээний (Сошиал медиа), платформын нийтлэл (Social Media Posts)	текст, видео, зураг болон бусад хэлбэрээр аль ч төрлийн мэдээллийн технологийн хэрэглүүрийг ашиглан нийтлэх, байршуулах, тэдгээрт сэтгэгдэл бичих, хариу үйлдэл (reaction) үзүүлэх, хуваалцах	Фейсбүүк, Twitter, Instagram, Youtube, TikTok, LinkedIn, Reddit болон тэдгээртэй төсөөтэй бусад

илэрхийлэх эрх чөлөө

[22] Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагааны эрх зүйн орчин, Олон улсын эрх зүй Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагаа, ЭШХ, 69 дэх тал, УБ., 2016.

[23] “Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХК-н “Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг цахим хуудсыг хаах замаар хязгаарлах арга хэмжээний зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ” судалгаа УБ.,2024.21 тал

Мэдээний нийтлэлийн тайлбар (Commentary on	Цаг үеийн шинжтэй үйл явдлын талаар сурвалжилсан мэдээний талаар санал бодлоо илэрхийлэхийн тулд мэдээллийн сүлжээ, цахим хуудсанд сэтгэгдэл бичих	Мэдээний цахим хуудас, нийгмийн сүлжээний хуудас
Нийтлэл бичих (Opinion Columns)	Өөрийн үзэл бодлыг илэрхийлсэн нийтлэл бичих	Цахим хуудас, онлайн сэтгүүл
Подкаст болон Влог (Podcasts and Vlogs)	аудио, эсвэл видео контент бүтээж, байршуулах	Youtube, Spotify болон тэдгээртэй төсөөтэй бусад
Шууд дамжуулалт (Live)	Шууд дамжуулах боломж бүхий платформуудыг ашиглан шууд дамжуулах байдлаар санал бодлоо тухайн цаг хугацаанд хуваалцах, илэрхийлэх;	Фейсбүүк, Instagram, Youtube болон тэдгээртэй төсөөтэй бусад
Вебинар болон цахим хурал (Webinars and Online Conferences)	тодорхой сэдвийн хүрээнд, товлосон цаг хугацаанд хэлэлцүүлэг, ярилцлага, хурал зохион байгуулах, түүнд оролцох	Zoom,Teams, Meets болон тэдгээртэй төсөөтэй бусад

Дээрх нь зөвхөн түгээмэл ашиглаж буй арга, хэлбэрүүд бөгөөд цаашид дижитал технологи үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж, ач холбогдол нэмэгдсээр байх юм.[24]

Гэвч хүмүүс олон нийтийн сүлжээг зөв зохистой ашиглахаас илүүтэйгээр хэмжээ хязгааргүй, цензургүй, ухамсар соёлгүй, ашиглаж худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг доромжлох, гүтгэх, энэ төрлийн зөрчил, гэмт хэрэг ихэд гарч байна. Энэ нь манай улсад төдийгүй дэлхийн улсуудад тулгамдаж буй асуудал болоод байна. Олон улсын жишгээс харахад олон нийтийн сүлжээг ашиглаж хүний нэр төр, алдар хүндэд халдах, гүтгэх, доромжлох үйлдлийг гэмт хэрэг “мөн”, “биш” гэх маргаан дагуулах болсноор, өөрийн улсын үнэт зүйл, онцлог байдалдаа тулгуурлаж уг харилцааг хууль тогтоомжоор зохицуулж байна.

Тухайлбал Манай улсын хувьд цахим орчинд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг доромжлох, гүтгэх, үйлдлийг иргэний буруу гэхээс илүүтэй гэмт хэргийн үндсэн шинж, сэдэл, учруулсан хор хөнөөлийг нарийвчлан тодорхойлж гэмт хэрэг гэж үзэж тусгайлсан хуулиар зохицуулахыг санал болгодог хэсэг байхад, нөгөө хэсэг нь үүнийг Үндсэн хууль, Иргэний хууль, журмаар зохицуулах, эсхүл хувь хүний өөрийнх нь соёлын хэмжүүр хэмээн хуваагдаж байна.

3.2. Цахим орчин дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээ

Дээр дурдсан цахим орчинд иргэд олон нийт орон зай цаг хугацааны хязгаарлалтгүйгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авах, түгээх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг эдлэх боловч нөгөөтэйгүүр үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах арга хэмжээг авах боломжтой юм.

Тодруулбал, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-н 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:

a/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;

b/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” хэмээн тусгасан байна.

НҮБ-ийн Ерөнхий Ассамблейс 2011 онд гаргасан Үзэл, бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай тусгай илтгэгчийн тайланд зааснаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах аливаа

[24] Council of Europe., Legal instruments., Recommendation CM/REC 13 (2022), The Impacts of Digital Technologies on Freedom of Expression., https://edoc.coe.int/en/international-law/11101- the-impacts-of-digital-technologies-on- freedom-of-expression-recommendation-cmrec202213. html. Сүүлд хандсан огноо: 2024.12.15

хязгаарлалт нь дараах үндсэн хэсгээс бүрдсэн, кумулятив шалгуурыг давах ёстой. Үүнд:

(a) Хязгаарлалтыг тодорхой бөгөөд хүн бүрт хүртээмжтэй байдлаар хуулиар зохицуулсан байх;

(b) Хязгаарлалтын зорилго нь “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-н 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зорилгуудад хамааралтай байх. Үүнд (i) бусдын эрх, нэр төрийг хамгаалах эсхүл (ii) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах;

(c) Хязгаарлалт нь зайлшгүй шаардлагатай бөгөөд хүний эрхийг хамгийн багаар хязгаарласан байх;

(d) Түүнчлэн иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буй хуулийг аливаа улс төр, бизнес, бусад ашиг сонирхлоос ангид, бие даасан байгууллага хянагддаг бөгөөд ингэхдээ аливаа дур зоргоос, ялгаварлан гадуурхах байдлаас ангид байх ёстой.[25] Тиймээс цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт хийх тохиолдолд “заавал хуулиар тогтоогдсон” байх, уг хуулийн зохицуулалт нь бусдын нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах гэсэн шаардлагуудад үндэслэх юм.

Мөн,Технологийн энэхүү эрин үед худал, ташаа мэдээлэл, үзэн ядсан үг хэллэг ихээр тархаж буйтай холбогдуулан Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) худал, ташаа мэдээлэл, үзэн ядсан үг хэллэгийн эсрэг Мэдээллийн нэгдмэл байдлын олон улсын зарчмыг баталжээ. Энэхүү олон улсын зарчим нь (i) нийгмийн итгэлцэл ба уян хатан байдал; (ii) эрүүл урамшуулал; (iii) олон нийтийн эрх мэдэл;
(iv) бие даасан, чөлөөт, олон ургальч хэвлэл мэдээллийн хэрэгсэл; (v) ил тод байдал ба судалгаа гэсэн үндсэн таван зарчмыг тогтоожээ.

Нийгмийн итгэлцэл гэдэгт хүмүүс өөрсдийн хүлээн авч буй мэдээллийн эх сурвалж, найдвартай байдалд итгэх итгэлийг ойлгох бол эрүүл урамшууллын зарчим нь одоогийн зар сурталчилгаа, зөвхөн мөнгө олоход чиглэсэн бизнесийн загварыг хүний эрхэд суурилсан хэлбэрээр эрүүл урамшууллын системээр өөрчлөх агуулгатай байна. Харин олон нийтийн эрх мэдэл нь хувь хүмүүст мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг шалгах эрх олгох, бие даасан, чөлөөт, олон ургальч хэвлэл мэдээллийн хэрэгслийн зарчим нь зар сурталчилгааны орлого хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ихээр нөлөөлж буйтай холбогдуулан эрх зүйт ёс, ардчиллын үндсэн элемент болох чөлөөт хэвлэл мэдээллийг хамгаалахад чиглэх ажээ. Эцэст нь ил тод байдал ба судалгааны зарчим нь технологийн компаниудын ил тод байдлыг нэмэгдүүлэх, хүний хувийн

[25] La Rue, Frank, UN. Human Rights Council, Special Rapporteur on the Promotion and Protection of the Right to Freedom of Opinion and Expression, 2011.05.27, https://digitallibrary.un.org/record/706200 [Сүүлд үзсэн огноо: 2025.12.15].

мэдээллийг боловсруулж, ашиглаж, түгээж буй процессын ил тод байдлыг хангахад чиглэсэн байна[26]

Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үндэслэл нь ИБУТЭОУП-аар тодорхойлсон шаардлагатай шууд холбоотой. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт зааснаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг (1) үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, (2) бусдын эрх чөлөө, эрх чөлөөг хүндэтгэх, (3) нийгмийн хэв журмыг сахиулах үндэслэлээр гагцхүү хуулиар хязгаарлана.

Монгол Улсын хувьд ХХЗХ нь Монгол Улсын холбогдох хууль эрх зүйн тогтолцооны дагуу аливаа онлайн контентын агуулгыг хууль зөрчсөн эсэхийг тогтоохгүй бөгөөд холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлэх, тогтоол шийдвэрийн дагуу технологийн зохицуулалт хийдэг байна. 2016 оноос хойш Харилцаа холбооны зохицуулах хороо болон Фэйсбүүк компанийн удаа дараагийн уулзалтаар Монгол Улсад аюулгүй, ёс зүйтэй нийгмийн сүлжээний орчныг бий болгоход хамтран ажиллах шаардлагатай гэдэгт санал нэгдсэн ба Фэйсбүүк компани нь өөрийн платформ дахь хуурамч хэрэглэгчийн бүртгэлийг устгах, хууль бус контентыг хязгаарлах чиглэлээр тус хороотой хамтран ажиллахаар болсон.[27] Үүний үр дүнд аливаа хууль бус контентын талаарх гомдол хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай “Government-Case-Work- Channel”[28] буюу шууд харилцах ногоон сувгийг 2019 оны 10 дугаар сард Монгол Улсад анх удаа албан ёсоор нэвтрүүлсэн. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд тус хороо нь 2020 оны Улсын Их Хурал, Орон нутаг болон 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацаанд үр дүнтэй хамтран ажилласан гэжээ.

Цаашлаад 2024 оны Улсын Их Хурлын сонгууль, Орон нутаг аймаг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хуульд нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хороо “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах түүнд хяналт тавих журмыг”[29] баталж, цахим орчны үйлчилгээ эрхлэгч, нэр дэвшигчийн болон нам, эсвлийн өөрийн цахим хуудас, цахим орчин дахь нийгмийн сүлжээний цахим хуудас зэрэг нэр томьёог тодорхойлсон. Тус журамд нам, эвсэл, нэр дэвшигч нар сонгуулийн сурталчилгааг цахим орчинд хэрхэн явуулах, цаашлаад нэр дэвшигчийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараасан зөрчилтэй цахим орчин дахь нийгмийн сүлжээний цахим хуудсыг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хаах, хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

<u>Цахим орчин дахь контентэд тавигдах шаардлага:</u>

Монгол Улсад Интернетээр дамжуулан контентын үйлчилгээ үзүүлэхэд

[26] https://www.jurist.org/news/2024/06/un-launches-global-principles-to-address-misinformation-disinformation-and-hate-speech/?fbclid=IwY2xjawIQDzVleHRuA2FlbQIxMAABHQz4ceE-098ksrx5Zsg7MRgu4-
[27] Онлайн контентын танилцуулга, 2022.05.01, https://crc.gov.mn/list/internetijn-s-lzhee-jlchilgee/mn
[28] “Government Case Work Channel” нь зөвхөн хууль бус, фэйсбүүкийн хэрэглэгчийн дагаж мөрдөх хэм хэмжээ
[29] Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

Монгол улсын холбогдох хуулиуд болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг мөрдлөг болгон Монгол Улсын хуулиар хориглоогүй контентийг хэрэглэгчдэд хүргэж ажиллах шаардлагатай бөгөөд хууль зөрчсөн контентуудыг 2 ангилдаг. Хүүхэд хамгаалах тухай хуулийн 8.2 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд залуучуудын хүмүүжилд сөрөг нөлөөтэй контентийн талаарх технологийн арга хэмжээг тус хороо нь яаралтайгаар авч хэрэгжүүлэх боломжтой.

1. Хүүхдэд сөрөг нөлөөтэй контент: яаралтай арга хэмжээ авна.

- Хүүхдийн бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, нүцгэн байдлаар дүрслэсэн контент
- Амиа хорлох, өөрийгөө гэмтээх зэрэг аюултай зан үйлийг өдөөн, турхирсан контент
- Хүүхэд, залуучуудын хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц контент
- Аюул занал, дарамт, дээрэлхэх агуулга бүхий контент
- Садар самуун бүхий контент
- Хүчирхийллийг агуулсан, уриалан дуудсан агуулга бүхий контент

2. Бусад контент: хуулийн байгууллагын албан ёсны шийдвэр, дүгнэлтийн дагуу арга хэмжээ авна.

- Бусдын нэрийг ашиглах, хуурамч мэдээлэл өгөх, залилангийн контент • Оюуны өмчийн зөрчилтэй контент
- Хувь хүний нууцлалтай холбоотой контент
- Үзэн ядсан агуулга бүхий контент
- Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг зөрчсөн контент
- Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг зөрчсөн контент гэх мэт.

Дээрх байдлаар хууль бус контентын агуулгыг тодорхойлоход Эрүүгийн хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулиас гадна Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг үндэслэжээ.[30]

Судалгаанаас харвал нийт хуурамч мэдээллийн 90 орчим хувь нь фэйсбүүк, дараа нь твиттер, тав орчим хувь нь л хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагддаг гэжээ. Үүнээс харахад хуурамч мэдээллийг сошиал хэрэглэгчид бид өөрсдөө л түгээж, дэвэргэж хөөсрүүлдэг байна. Тиймээс аливаа эргэлзээтэй, хэт

[30] 19Харилцаа холбооны зохицуулах хороо., Цахим орчны зохицуулалт (зөвлөмж)., 2021., https://crc.gov.mn/storage/1.2%20%D0%A6%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC%20%D0%BE%D1%80%D1%87%D0%BD%D1%8B%20%D0%B7%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%BC%D0%B6.pdf ., Сүүлд хандсан огноо: 2024.12.15

нэг талыг барьсан мэдээллийг түгээж хөөсрүүлэхээсээ өмнө эх сурвалжаар баталгаажуулах, нягтлах нь хамгийн чухал байгаа талаар “Мэдээллийг талх гэж бодвол шууд идэх биш ямар орц найрлагатай, хэзээ үйлдвэрлэсэн, хортой юу, хоргүй юу гэдгийг нь харж байж амандаа хийх ёстой. Өнөөдрийг хүртэлх ертөнцөд мэдээлэл бол хүч гэж хэлдэг байсан. Энэ цаг үеэс хойш хүнийг хүчгүй болгоё гэвэл мэдээллээр бөмбөгд гэж хэлэх болсон. Ирээдүйд гаргах шийдвэртээ хамгийн хэрэгтэйг нь ашиглая гэвэл мэдээллээ ялгаж, салгаж сурах хэрэгтэй. Ignore хийх буюу үл тоох, тоохгүй хаях чадвартай болох ёстой. Бүх мэдээллийг аваад л сэтгэлээ хөдөлгөөд л, энергиэ зарцуулаад, ойр тойрныхондоо түгээгээд байвал мэдээллээр тоглуулна л гэсэн үг” гэж FactCheck.mn талбарынхан хэлж байна. [31]

Түүнчлэн 2021 онд батлагдаж хүчин төгөлдөр үйлчилж буй Кибер аюулгүй байдлын тухай хууль [32]21-иар кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо, зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж байна. Мөн хуулиар үүрэг хүлээх этгээдүүдийн үүргийг тусгайлан зохицуулсан байна. Үүнд: ЗГ, Кибер аюулгүй байдлын зөвлөл, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Цагдаагийн байгууллага, Төрийн өмчит хуулийн этгээд, Хуулийн этгээд, Иргэн гэх мэт тодруулбал тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.1- т “Иргэн кибер аюулгүй байдлыг хангах талаар дараах үүргийг хүлээнэ:” 18.1.1-т “өөрийн болон өөрийн асрамжид байгаа хүний кибер аюулгүй байдлыг хариуцах”, 18.1.2-т“холбогдох байгууллагаас гаргасан зөвлөмжийг дагах, шаардлагыг биелүүлэх”, 18.2-т “Кибер халдлага, зөрчил үүссэн, үүссэн байж болзошгүй тохиолдолд Нийтийн төвд даруй мэдэгдэж болно.” гэж үүрэг хүлээжээ. Хуулийн энэхүү зохицуулалтаас үзвэл цахим орчинд өөрийн болон эцэг, эх, үр хүүхэд, гэр бүлийн гишүүдийн мэдээллийг хамгаалах, халдлага өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ойлгохоор байна. Жишээлбэл хүүхдийнхээ авч буй мэдээлэл, хандаж буй сайт, үзэж буй контент гэх мэт.

2021 онд батлагдаж хүчин төгөлдөр үйлчилж буй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль [33]-иар хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох харилцааг зохицуулж байна. Хуулиар нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай хэмээн 3 ангилан хуульчилсан. Одоогоор 68 төрлийн нээлттэй мэдээллийг иргэд чөлөөтэйгөөр авч байна. Энэ нь манай улсын хувьд төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байх, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангаж байна.

2021 онд батлагдаж хүчин төгөлдөр үйлчилж Хүний хувийн мэдээлэл

[31] Нийтлэлч С.Уянга Fake news нийгэмд ямар хор “шахдаг” вэ? нийтлэл https://www.polit.mn/a/104927
[32] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061
[33] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601

хамгаалах тухай хууль [34]-иар хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж байна. Энэхүү хуулийн онцлог нь Сэтгүүл зүйн, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж болохоор хуульчилсан байна. Түүнчлэн мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр хүний хувийн мэдээлэл, эмзэг мэдээллийг задруулахгүйгээр, аюулгүй байдлыг хангах, алдахаас сэргийлэх арга хэмжээг мэдээлэл хариуцагч хариуцах, мэдээллийн эзний эрх, мэдээллийн эзний үүргийг хуульчил нь онцлогтой байна.

3.3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.

3.3.1. Эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан буюу https://shuukh.mn// -д 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан **“худал мэдээлэл тараах”** гэмт хэргээр зүйлчилж шийдвэрлэсэн нийт **141** шүүхийн шийдвэрийн байна. Үүнээс уг төрлийн гэмт хэргийн дийлэнх нь цахим орчинд олон нийтийн мэдээллийн цахим сүлжээнд /Facebook, twitter мэдээллийн сайт, телевиз/ үйлдэгджээ.

Шүүхийн практикт бусдын нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг цахим орчинд тараасан тохиолдлыг гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулан шийдвэрлэж байна. Дүн шинжилгээ хийсэн шүүхийн шийдвэрээс үзвэл 90 орчим хувь нь эрүүгийн хариуцлага хүлээлгэн шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 2 Эрүүгийн шүүхийн шийдвэрийн тоон мэдээлэл

Эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн						Нийт	УБ хот	ОН	ФБ	Твиттер	Сайт	Сонин сэтгүүл
Шүүх	2020	2021	2022	2023	2024	141						
Анхан шатны шүүх	8	20	15	34	34	111	50	61	89	2	5	1
Давж шатны шүүх	0	6	6	7	9	28	26	2	24	1	5	0
Улсын дээд шүүх	0	0	0	0	2	2	0	0	2	0	0	0

[34] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390288615991

2020, 2021, 2022, 2023, 2024 онд шүүхээр шийдвэрлэгдсэн худал мэдээлэл тараах гэмт хэрэг, түүний шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийн, нэгтгэн дүгнэж дор дурдсан дүгнэлтийг гаргалаа.

1. Шүүхийн практикт бусдын нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг цахим орчинд тараасан тохиолдлыг гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулан шийдвэрлэж байна.
2. Гэр бүлээс гадуурх харилцааны улмаас үүссэн хэрүүл маргааныг олон нийгмийн сүлжээнд аймаг орон нутгийн зарын группэд хуурам цахим хаяг үүсгэж ёс бусаар доромжилсон утга агуулгатай пост нийтэлж оруулах, хоорондын бичсэн чат мессежийг дэлгэж байна. Энэ талаар шүүгдэгч нар шүүх хуралдаан дээр уурласан, хорссон, үзэн ядсан, гомдсон учраас би ийм зүйл хийсэн гэдгээ хүлээн зөвшөөрч тайлбарлаж байна. Мөн насанд хүрээгүй охид эмэгтэйчүүдийг садар самуунд уруу татах, заналхийлэх, “санхүү өгнө авна” гэх группэд зураг, утасны дугаарын санаатайгаар нийтэлж пост оруулах, зөвхөн нэг зарын группэд нийтлээд зогсохгүй хүн ихтэй 2 ба түүнээс дээш группэд нийтэлж буй түгээмэл байна.
3. УИХ-н гишүүд, Сайд, Цагдаагийн албан хаагч, Аймаг орон нутгийн засаг дарга нарын эрхэлж буй ажил, албан тушаал, ажил үүрэгтэй холбогдуулан цахим орчин мэргэжлийн сэтгүүлч нар өөрийн эрхлэн ажилуулж буй цахим хуудас, вэб сайтаар дамжуулан нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан гэх гомдлын цөөнгүй хэрэг хянан шийдвэрлэгдсэн байна. Жишээлбэл Сэтгүүлч Шинэбаяр Шадар сайд Амарсайханы гомдлоор, ХЗДХЯ-н Сайд Х.Нямбаатарын гомдлоор, Монгол 3-р сургуулийн захирал Ж.Соронзогийн гомдлоор, Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн зургийг эвлүүлж нийтэлсэн гэх гомдлоор, Улсын Ерөнхий прокурор, Шүүх, Цагдаагийн Ерөнхий газар зэрэг байгууллагын ажил хэргийн нэр хүндэд халдсан гэх гомдлын дагуу мэргэжлийн сэтгүүлч нарын зүгээс хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчсөн талаар шүүх дүгнэж сэтгүүлч болон цахим сайтуудын эрхлэгч нарт эрүүгийн хариуцлага хүлээлгэж, шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр цөөнгүй байна. Энэ нь сэтгүүл зүйн салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн ёс зүйн зарчмыг баримтлах, иргэд олон нийтэд мэдээ мэдээллийг хүргэхдээ үнэн бодит, тал бүрээс шинжлэн судалж хүргэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.
4. Шүүхийн шийдвэрээс үзвэл мэргэжлийн сэтгүүлч, сайтын эрхлэгч нарын хэрэг нь талууд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа үйлчилгээ авах, өмгөөлүүлэх, худал мэдээлэл тараагаагүй гэдэг байр суурийг баталж, мэтгэлцэж шүүх хуралдаан дээр тайлбарыг гаргаж хэргийг шийдвэрлүүлж байгаа бол нөгөөтээгүүр гэр бүлээс гадуурх харилцааны улмаас үүссэн, эхнэр нөхрөө хардсан, бусдад хувийн өс хонзон санасан, уурлаж хорссон, 2 ба түүнээс дээш зарын группэд, санхүү өгнө авна гэх агуугаар пост нийтэлсэн гэх

хэргүүдийн хувьд шүүгдэгч нь гэм буруугаа хүлээн зөвшөөрч оногдуулах боломжит хамгийн бага ялыг өгөхийг хүсэж шийдвэрлүүлсэн цөөнгүй шүүхийн шийдвэр байна. Мөн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх явцад шүүгчдэгчдийн хувийн байдлыг харгалзан үзэхэд ихэнхдээ тусгай, бага, бүрэнд дунд боловсролтой иргэд байх нь түгээмэл байна. Энэ нь иргэдийн цахим орчныг соёлтой ашиглах, үзэл бодлоо хэрхэн илэрхийлэх болон бусдын эрх миний эрхээр хязгаарлагддаг талаар эрх зүйн анхан шатны мэдлэг боловсрол дутмаг байгааг илэрхийлж байна.

5. Хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан гэх гомдлын хүрээнд хэд хэдэн хэргийг шүүх шийдвэрлэсэн байна.
6. Эхний хэсэгт дурдсанчлан иргэн Ж.Баттул нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16,17 дахь заалтын зарим хэсгийг зөрчиж буй талаар мэдээлэл гаргаж Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2024 оны 08-р сарын 01-ны өдөр “Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай” дугаар 98 тогтоол гаргасан. Уг тогтоол гарснаар шүүгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3-т "Тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол хэргийг түдгэлзүүлнэ" гэж заасны дагуу хэргийг түдгэлзүүлэх эрхийн актыг гаргах ёстой. Гэтэл 2024 оны 08-р сарын 01-ны өдрөөс хойш Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлээр зүйлчилж Анхан, Давж заалдах, Улсын Дээд шүүх нь нийт 25 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж эрүүгийн хариуцлагыг оногдуулсан байна.
7. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа нөхцөл байдлыг бүрэн шалгаж тогтоохгүй, зөвхөн гомдол, өргөдөл гаргагч этгээдийн өгсөн мэдээлэл, баримтад тулгуурлан үнэн, худлыг шүүн дүгнэлт хийх, мэдээлэл тараасан этгээдийг буруутгах хандлага, практик мөрдөн шалгах, прокурор, шүүхийн шатанд илэрч байна. Улмаар шүүхээс хэргийн прокурорт мөрдөн байцаалтад буцаах шийдвэрүүд цөөнгүй гарч байна.
8. Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт доромжлох гэсэн агуулга шууд тусгагдаагүй, харин шүүхийн практикт худал мэдээлэл тараах гэдэгт доромжлох үйлдлийг хамруулан хэрэглэж байна. “Доромжлох” гэдэг нь хууль зүйн хувьд нийтээр тогтсон ёс суртахуун, зан үйлийн хэм хэмжээг үл хүндэтгэн, хүнийг доог тохуу болгох зорилгоор сөргөөр буюу зүй бус, зохисгүй байдлаар нэрлэж, дуудаж, үнэлж бичих, хүний зан үйл, зан төлөвийн үнэн бодит байдал, хүний алдар хүндэтгэлийг гуйвуулан үгүйсгэж буй явдал юм. Жишээ нь, хүнд хоч өгөх, гарал үүсэл, яс үндэс, биеийн гадаад хэлбэр, бие эрхтний гажиг, ажил мэргэжил зэргээр нь доромжлох зэрэг маргаан гарч байна.

3.3.2. Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:

Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуулиудад зохицуулсан байдаг. Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. Иргэний хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө гэжээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ сэргээн тогтоолгох эрхтэй гэж заажээ.

Эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ сэргээн тогтоолгох эрхтэй гэж заажээ. Эд хөрөнгийн хохирол /материаллаг хохирол/ нь гэм хорын мөнгөн хэлбэрээр тодорхойлогдсон үнэлгээ, хэмжээ гэж ойлговол эд хөрөнгийн бус буюу эдийн бус гэм хор /материаллаг бус/ нь хүний эрүүл мэндийг сарниулах, амь насыг хохироох, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдах, гутаах, доромжлох, хувийн нууцад халдах зэргээр тухайн субъектын амин хувийн эрхийг зөрчих явдлаар илэрнэ. Эрх зүйт төр, иргэний ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцдаг бол эрх нь зөрчигдсөн иргэн өөрийн эрх, эрх чөлөөг хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслээр хамгаалах, түүний дотор учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан буюу https://shuukh.mn// -д 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд заасан “эдийн бус гэмт хорыг арилга /нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан/” шийдвэрлэсэн нийт **242** шүүхийн шийдвэрийн байна. Үүнээс үзвэл дийлэнх маргаан нь цахим орчинд олон нийтийн мэдээллийн цахим сүлжээнд /Facebook, twitter мэдээллийн сайт, телевиз, ажлын байр, ажлын байранд, ор үндэслэлгүйгээр хуулийн байгууллагаар шалгуулах гэх мэт/ маргаан шийдвэрлэгджээ.

Эд хөрөнгийн бус амины харилцаа нь эдийн бус харилцаанд хамаарах дараагийн төрлийн харилцаа нь тухайн хүний хувийн байдалтай салшгүй холбогдох эдийн бус эрх, эрх чөлөөтэй холбоотой үүсэх амины эрхийн харилцаа юм. Энэхүү амины эрхийн харилцаанд “нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд”, “хувийн ашиг сонирхол” “хувийн амьдрал, захидал харилцааны нууц” зэрэг амин хувийн ашиг сонирхолтой холбогдох харилцаа багтдаг. Хэдийгээр уг харилцаа нь мөнгөн “эквивалент” шинж байхгүй буюу илэрхий эдийн засгийн агуулгагүй боловч өөрийн гэсэн үнэ цэнтэй байдаг. Эдгээр нь субъектээс салшгүй шинжтэй байдаг учраас

“амины” гэж нэрлэгддэг.[35]

Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй”, мөн зүйлийн 21.5-д “Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.”

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан буюу https://shuukh.mn// -д 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд заасан “эдийн бус гэмт хорыг арилга /нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан/” шийдвэрлэсэн нийт **242** шүүхийн шийдвэрийн байна. Үүнээс үзвэл дийлэнх маргаан нь цахим орчинд олон нийтийн мэдээллийн цахим сүлжээнд /Facebook, twitter мэдээллийн сайт, телевиз, ажлын байр, ажлын байранд, ор үндэслэлгүйгээр хуулийн байгууллагаар шалгуулах гэх мэт/ маргаан байх бөгөөд шүүхийн практикт Эдийн бус гэм хор арилгах /нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан/ маргаан нь талуудын үндэслэл тайлбараа нотолж, няцааж буй талуудын гаргаж, цуглуулж өгсөн нотлох баримтын хүрээнд хэргийн хянан шийдвэрлэж буй нь ажиглагдаж байна.

Хүснэгт 3 Иргэний шүүхийн шийдвэрийн тоон мэдээлэл

Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн						Нийт
Шүүх	2020	2021	2022	2023	2024	242
Анхан шатны шүүх	34	43	22	35	37	171
Давж шатны шүүх	15	7	9	19	11	61
Улсын дээд шүүх	1	1	6	0	2	10

2020, 2021, 2022, 2023, 2024 онд Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн Эдийн бус гэм хор арилгах /нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан/ мэдээлэл тараах гэмт хэрэг, түүний шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийн, нэгтгэн дүгнэж дор дурдсан дүгнэлтийг гаргалаа.

1. Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэгт “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ

[35] Ж.Оюунтунгалаг. Иргэний эрх зүй I., Ерөнхий анги, УБ., 2020 он 30-31 дэх тал.

бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.” гэсэн ба үүнд дурдсан гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгах зохицуулалт хийгдсэн байна. Улмаар Иргэний хуулийн 21, 511 дүгээр зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгахдаа хэрхэн тооцож шийдвэрлэж буй талаарх аргачлалгүй байна.

2. Шийдвэрээс үзвэл гутаан доромжлох болон шүүмжлэх хоёрын ялгааг онолын болон хууль зүйн хувьд ялгааг гаргалгүйгээр доромжлох гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхой буй хэвээр шүүх шийдвэрлэж байна. Угтаа бол гутаан доромжлох гэдэг нь хувь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд шууд халдаж буй хэлбэр бол шүүмжлэл гэдэг нь тухайн хүний ажил, мэргэжилдээ хэрхэн хандаж буйг хувь хүний зүгээс үнэлэлт дүгнэлт өгч буй хэлбэр гэж үзэх нь оновчтой юм.

3. Монгол Улсад хуулийн хэрэгжилтэд учирч байгаа хүндрэл бэрхшээл нь гэмт хэргийн улмаас хохирсон хүний хохирол арилахгүй, зөрчигдсөн эрх нөхөн сэргээлгэхгүй байгаа нь нийгмийн болон хууль зүйн шинжлэх ухааны өмнө тулгамдсан асуудал болсоор байна. Монгол Улсын Үндсэн хуульд хүний хувийн амьдралд, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндийг хүний үндсэн эрх эрх чөлөөний нэг бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлж хамгаалахаар заасан байна. Монголчуудын ёс зүйн түүхэн уламжлалт өв соёлд “Эд хөрөнгөө алдвал багыг алдсанд тооц, нэр төрөө алдвал ихийг алдсанд тооц, эрүүл мэндээ алдвал бүгдийг алдсанд тооц” хэмээн хүнийг доромжлох гүтгэх гэмт үйлдлийн үр дагавраас болоод хүний нөр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл санааны гэм хор уршиг бас бий болох нь тодорхой юм.

ГУРАВ.ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Дэлхий улс орнууд олон улсын нэгдэн орсон гэрээ конвенцийн дагуу үндэсний хууль тогтоомждоо үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хуульчлан баталгаажуулж өгсөн байна. Ингэхдээ үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхдээ бусдын нэр төр, алдар хүндийг гутаахгүйгээр чөлөөтэй илэрхийлээр зохицуулжээ.

Манай улсын эрх зүйн бүлд хамаарах Герман, ОХУ- дэлхийн дахин цахим үндэстэн хэмээн нэрлэгддэг Эстон улс, Хамгийн олон хохирогчтой гэгдэг цахим гэмт хэргийг илрүүлж шалгасан гэх БНСУ-иудын сонгон авч, холбогдох хуулиадад үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хязгаарлалтыг хэрхэн хуульчилсан талаар судлан үзье.

3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ Интернэтийн эрх чөлөөг хангалттай түвшинд хэрэгжүүлж буй ХБНГУ бусдын нэр төрд халдахгүйгээр хүн бүр өөрийн үзэл бодлыг аливаа хязгаарлалтгүйгээр эдлэх эрх чөлөөг Үндсэн хуулиараа баталгаажуулсан.[36] Мөн олон нийтийн сүлжээн дэх зохистой агуулгын эсрэг гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, олон нийтийн сүлжээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх харилцааг Олон нийтийн сүлжээнд хуулийн хэрэгжилтийг дээшлүүлэх тухай (“The Act on Promotion of Information and Communications Network Utilization and Information Protection”) хуулиар [37]26зохицуулдаг. Тус хууль нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн томоохон платформуудын хариуцлага, ил тод байдлыг хангахын зэрэгцээ үзэл бодлоо илэрхийлэх эрх болон хууль тогтоомжийн сөрөг нөлөөллийн асуудлыг зохицуулдаг. Мөн дараах Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг хууль бус контент гэх тодорхойлолтод хамруулсан байна. Үүнд

- 86 дугаар зүйл. Үндсэн хууль зөрчсөн болон террорист үйл ажиллагааны талаарх суртал ухуулгын материал тараах,
- 86 а дугаар зүйл. Үндсэн хууль зөрчсөн болон террорист үйл ажиллагааны талаарх тэмдэг, тэмдэглэгээ ашиглах,
- 89 а дугаар зүйл. Онц аюултай хүчирхийллийн гэмт хэрэгт бэлтгэх,
- 91 дүгээр зүйл. Улсад онц аюултай хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэх төлөвлөгөө боловсруулах,
- 100 а дугаар зүйл. Эх орноосоо урвахаар хуурамч баримт бичиг үйлдэх,
- 111 дүгээр зүйл. Олон нийтийн эсрэг гэмт хэрэг үйлдэхэд уриалах,,
- 126 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр заналхийлэх замаар олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах,,
- 129 дүгээр зүйл. Гэмт бүлэглэл үүсгэн байгуулах ,,
- 129 b дүгээр зүйл.Террорист бүлгэм үүсгэх,

[36] Federal Ministry of Justice website “Basic Law for the Federal Republic of Germany” https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html Сүүлд хандсан огноо: 2024.06.26
[37] The Network Enforcement Act (Netzwerkdurchsetzungsgesetz, NetzDG).

- 130 дугаар зүйл. Олон нийтийг турхирах,
- 131 дүгээр зүйл. Хүчирхийллийг дүрслэх,
- 140 дүгээр зүйл. Гэмт хэргийг урамшуулах, сайшаах,
- 166 дугаар зүйл. Шашны болон үзэл суртлыг доромжлох,
- 184 b дүгээр зүйл. Хүүхдийн садар самууныг агуулсан контентыг түгээх, худалдан авах, хадгалах,
- 185 дугаар зүйл. Доромжлох,
- 186 дугаар зүйл. Ёс бус үг хэллэг хэрэглэх,
- 187 дугаар зүйл. Гутгэх,
- 201 а дугаар зүйл. Гэрэл зураг дарах болон бусад зургийн хэрэгслээр хувь хүний нууцлалд халдах,
- 241 дүгээр зүйл. Онц аюултай гэмт хэрэг үйлдэхээр заналхийлэх,
- 269 дүгээр зүйл. Нотолгооны ач холбогдол бүхий мэдээллийг хуурамчаар үйлдэх зэрэг багтана

ХБНГУ-н Эрүүгийн хуулиар гутгэх, доромжлох гэмт хэргийг тусад нь хуульчилжээ. [38] Монгол Улсын хувьд доромжлох гэмт хэргийг Эрүүгийн хуулиас халсан ч шүүхийн практикаас харахад доромжлох үйлдлийг худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хамруулан шийдвэрлэж байна.

3.2. Оросын холбооны улс

ОХУ нь “Интернет дэх хуурамч мэдээлэлттэй тэмцэх тухай” [39]хуультай ба энэ хуулиар хуурамч мэдээлэл тараасан хүмүүс, хэвлэл мэдээллийн байгууллагад өндөр торгууль, хорих ял оногдуулахаар хуульчилсан байдаг.

Түүнчлэн ОХУ-ын Эрүүгийн хуулийн арван долоодугаар бүлэгт хувь хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэргүүдийг багтаасан байх бөгөөд тус хуулийн 128.1 дугаар зүйлд “гутгэх гэмт хэрэг”-ийн талаар заажээ. Гутгэх гэсэн ойлголтыг “нэр төрийг санаатайгаар гутааж буюу нэр хүндэд нь халдаж”, “хуурамч мэдээлэл” тараасан бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна. Уг зүйлд нэр төрийг санаатай гутаасан байх субьектив санаа зорилгыг гэмт хэргийн гол шинж болгож заасан байна.

Арван долоодугаар бүлэг. Хувь хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэрэг 128.1 дүгээр зүйл. Гутгэх (1) Бусдын нэр төрийг санаатайгаар гутааж буюу нэр хүндэд нь халдаж, хуурамч мэдээлэл тараасан бол таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны зургаан сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл зуун жаран цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ. (2) Олон нийтийн өмнө ярьсан, эсхүл нийтэд бүтээлээр үзүүлсэн,

[38] Э.Хилгендорф, Д.Чанцалдулам, Германы Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, УБ., 2015, 31 дэх тал.
[39] "Борьба с фейковыми новостями в интернете" 2019 он

мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүний нэр төрд халдсан бол нэг сая хүртэл рубль эсхүл ялтны нэг жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ. (3) Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглан үйлдсэн бол хоёр сая хүртэл рубль эсхүл ялтны хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл гурван зуун хорин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ. (4) Бусдад аюул учруулж болзошгүй хүнд өвчтэй гэж гүтгэсэн бол гурван сая хүртэл рубль эсхүл ялтны гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. (5) Бэлгийн хүчирхийллийн хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж гүтгэсэн бол таван сая хүртэл рубль эсвэл ялтны гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар баривчлах эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж хуульчилсан байна.

ОХУ нь Эрүүгийн хуульдаа Бусдын нэр төрийг санаатайгаар гутааж буюу нэр хүндэд нь халдаж, хуурамч мэдээлэл тараасан үйлдлийг эрүүгийн гэмт хэрэг хэмээн хуульчилж албадлагын аргаа хэмжээ авах баривчлан хүртэл ял шийтгэлийг оногдуулдаг байна. Түүнчлэн ямар мэдээллийг ямар агуулгатайгаар нийтэлсэн бол гэмт хэрэгт тооцон ял шийтгэж буйг хуулиараа нарийвлан зохицуулжээ.

3.3. Бүгд Найрамдах Эстони Улс

БНЭУ нь цахим орчин дахь хэрэглэгчдийн эрх ашгийг өндөр хэмжээнд хамгаалдаг бөгөөд Засгийн газраас зохистой хязгаарлалтыг хэрэгжүүлдэг. Freedom house-с 2022 онд гаргасан “Цахим орчин дахь хүний эрхийн хэрэгжилт”-ийн талаархи судалгаагаар БНЭУ нь 100-с 93 оноо буюу үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хэрэгжилт өндөр улсын тоонд багтсан байна. Тус улс нь цахим орчин дахь харилцааг Олон нийтийн сүлжээний тухай хуулиар (Law enforcement act) [40]28зохицуулдаг. БНЭУ-ын Засгийн газраас цахим хуудас, цахим сүлжээн дэх мэдээ, мэдээлэлд дараах зохицуулалтууд хэрэгждэг. Үүнд:

- 2021 оны байдлаар 1600 холболтын линк бүхий, зөвшөөрөлгүй цахим мөрийтэй тоглоомын вэб сайтуудын жагсаалтыг гаргаж, тэдгээрийн хандах эрхийг хаахыг цахим үйлчилгээ үзүүлэгчдэд үүрэг болгосон байна. Дээрх жагсаалтыг Татварын албанаас хөтөлж, ил тод нийтэлдэг.
- Европын Холбооны Аудио-Дүрс Хэвлэл мэдээллийн үйлчилгээний удирдамж (AVMSD)161 нь 2022 оны 3 дугаар сард батлагдсан бөгөөд тус удирдамжийн

[40] Law Enforcement Act, https://www.riigiteataja.ee/en/eli/504012016003/consolide [Сүүлд үзсэн огноо: 2024.12.15]

дагуу видео түгээх платформууд[41]-аас насанд хүрээгүй хүүхдийг бие бялдар, оюун ухаан, ёс суртахуунд нь сөргөөр нөлөөлж болзошгүй контентоос хамгаалахын тулд садар самуун, хүчирхийлэл, түрэмгийлэл, терроризм, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах агуулгатай контентын эсрэг удирдамжид заасан "зохих арга хэмжээ"-нүүдийг авахыг шаарддаг. [42]

- Дижитал зах зээл дэх зохиогчийн эрхийн тухай Европын холбооны удирдамжийг БНЭУ дотоодын хууль тогтоомждоо тусгасан байна. Уг зохицуулалтын дагуу “цахим контент түгээгч[43] нь удирдамжид заасан арга хэмжээг авч хэрэгжүүлээгүйн улмаас өөрийн платформ дээр үүссэн зохиогчийн эрхийн зөрчилд хамтран хариуцлага хүлээнэ /partially/.[44]
- Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхсан үг хэллэг, илэрхийллийг Эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг тооцож торгуулийн ялаар шийтгэдэг бөгөөд дээрх үйлдлийн улмаас хүний амь нас хохирсон эсхүл хүнд хохирол учирсан бол 3 хүртэлх жилийн хорих ял шийтгэнэ[45].БНЭУ нь 2002 онд гүтгэлгийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохоо больсон бөгөөд иргэний журмаар Үүргийн эрх зүйн хуулийн[46]дагуу шийдвэрлэдэг.

Түүнчлэн БНЭУ-д цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон цахим орчинд хандах эрхийг цөөн тохиолдолд хязгаарладаг. Эстони Улсын Үндсэн хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу хүн бүр үзэл бодол, итгэл үнэмшил болон бусад мэдээллийг үг, хэвлэмэл, зураг болон бусад хэлбэрээр чөлөөтэй түгээх эрхтэй. Энэ эрхийг нийтийн хэв журам, нийтийн ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндийг хамгаалах зорилгоор хуулиар хязгаарлаж болно. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах гол үндэслэл нь хуулиар хориглосон үйлдэлтэй салшгүй холбоотой. Тиймээс дараах тохиолдолд

[41] Based on their definition under Article 1(1)(aa) of the AVMSD, video-sharing platform services may be identified on the basis of the following three criteria:
[42] 30 Freedom on the Net: Estonia, The Freedom House, 2022, https://freedomhouse.org/country/estonia/freedom-net/2022#footnote8_ld4ljal [Сүүлд үзсэн огноо: 2024.12.15].
[43] Directive (EU) 2019/790 of the European Parliament and of the Council of 17 April 2019, European Union Law, Article
17.4 “If no authorisation is granted, online content-sharing service providers shall be liable for unauthorized acts of communication to the public, including making available to the public, of copyright-protected works and other subject matter, unless the service providers demonstrate that they have: (a) made best efforts to obtain an authorisation, and (b) made, in accordance with high industry standards of professional diligence, best efforts to ensure the unavailability of specific works and other subject matter for which the right holders have provided the service providers with the relevant and necessary information; and in any event (c) acted expeditiously, upon receiving a sufficiently substantiated notice from the right holders, to disable access to, or to remove from their websites, the notified works or other subject matter, and made best efforts to prevent their future uploads in accordance with point (b)”
[44] Freedom on the Net: Estonia, The Freedom House, 2022, https://freedomhouse.org/country/estonia/freedom-net/2022#footnote8_ld4ljal [Сүүлд үзсэн огноо: 2024.12.15].
[45] Estonian Penal Code, Article 151.
[46] Law on Obligations, 2001.

үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хязгаарлагдана. Үүнд:

Эстони Улсын Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэгт Улс төрийн болон иргэний эрхийн эсрэг зөрчил хуульчилсан.

Гүтгэлэг, доромжлол: 157 Бусдын хувийн мэдээллийг хууль бусаар ашиглах Өөр хүний нэрийг тогтоох, тогтоох боломжтой хувийн мэдээллийг дамжуулах, мэдээлэлд хандах эрх олгох, түүний зөвшөөрөлгүйгээр тухайн хүний талаар санаатайгаар буруу ойлголт төрүүлэх зорилгоор ашиглах. тухайн этгээдийг таниулах, өөрөөр хэлбэл хуулиар хамгаалагдсан бусад хүний эрх, ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл гэмт хэргийг нуун дарагдуулсан бол мөнгөн шийтгэл хүлээлгэнэ. шийтгэл, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих. Үүнтэй ижил үйлдлийг хуулийн этгээд үйлдсэн бол мөнгөн торгууль ногдуулна. Мөн хуулийн 247 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Олон Улсын халдашгүй дархан эрхтэй хүн, түүний гэр бүлийн гишүүнийг гүтгэсэн, доромжилсон бол хүнийг торгох ял эсвэл 2 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ”; мөн хуулийн 275 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Олон нийтийн хэв журмыг сахиулах төрийн албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан доромжилсон бол хүнийг гурван зуун нэгжээр торгох, эсхүл баривчлах ялаар шийтгэнэ”; мөн хуулийн 305 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүх болон шүүгчийг шударга ёсыг хэрэгжүүлэхэд оролцсонтой нь холбогдуулан доромжилсон бол хүнийг 300 хүртэл нэгжээр торгох, эсхүл баривчлах ялаар шийтгэхээр хуульчилсан байна.

3.4. Бүгд Найрамдах Өмнөд Солонгос Улс

Тус улсад кибер гэмт хэргийг “Cyber-terror Type Crime” буюу хортой вирус ашиглан компьютерийн төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдалд халдсан гэмт хэрэг, “General Cybercrime” буюу цахим тоног төхөөрөмж, интернэт ашиглан үйлддэг интернэт залилан, хүүхдийн эсрэг садар самуун, оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг, зөрчлүүд ангилан авч үздэг.

Солонгос улсын харилцаа холбооны салбарт 4 гол хууль үйлчилдэг. Нэгдүгээрт харилцаа холбооны бизнесийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тавьж, холбогдох журмыг тодорхойлох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилго бүхий Харилцаа холбооны үйл ажиллагааны тухай хууль, хоёрдугаарт харилцаа холбооны үйл ажиллагааны нөхцөл шаардлагад тавигдах үндсэн эрх зүйн зохицуулалтыг агуулсан Харилцаа холбооны зохицуулалтын тухай хууль, радио сүлжээг үр дүнтэй удирдах талаар зохицуулах Радио сүлжээний тухай акт, түүнчлэн хэрэглэгчийн хувь хүний эрхийг хамгаалах, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний үр дүнтэй байдлыг дэмжихэд чиглэсэн Мэдээллийн аюулгүй байдал, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний үр дүнтэй байдлыг дэмжих тухай хуультай байна.

Харилцаа холбооны үйл ажиллагааны тухай хуульд зааснаар харилцаа холбооны үйлчилгээг 3 үндсэн төрөлд ангилдаг. Үүнд харилцаа холбооны үндсэн сүлжээний үйлчилгээ, харилцаа холбооны тусгай сүлжээний үйлчилгээ болон

харилцаа холбооны өртөг нэмэгдсэн үйлчилгээнүүд /value-added telecoms/ юм. Мэдээллийн сүлжээний үйлчилгээ, цахим мэдээ, мэдээлэл, цахим худалдаа, арилжааны үйлчилгээнүүд нь Харилцаа холбооны өртөг нэмэгдсэн үйлчилгээнд хамаарах бөгөөд Харилцаа холбоо, мэдээллийн яамд бүртгүүлснээр үйл ажиллагаа эрхлэх үүрэгтэй байна.

3.5.Европын Холбоо

Европын Холбоо хуурамч мэдээллийн эсрэг хатуу арга хэмжээ авдаг ба 2018 онд "Дезинформацийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө" гаргаж, интернэт дэх хуурамч мэдээллийг арилгах, үнэн зөв мэдээлэл түгээхэд анхаарч байна. Хэрэглэгчдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх, цахим орчны аюулгүй байдлыг хангаж байна. Түүнчлэн Зарим ЕХ-ны улс орнууд тухайлбал, Франц, Герман, Итали улс сонгуулийн үеэр худал мэдээлэл тараахыг хориглосон хуулиудтай. Мөн Зүүн өмнөд азийн улс болох Сингапур улсын хувьд мөн адил "Хуурамч мэдээллийн эсрэг хууль" (Protection from Online Falsehoods and Manipulation Act - POFMA) 2019 онд батлагдсан. Тус хууль нь цахим орчинд хуурамч мэдээлэл тараасан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, мэдээллийг устгах эсвэл залруулах үүрэг өгдөг байна. БНХАУ Цахим аюулгүй байдлын хууль (Cybersecurity Law) – Хятадын засгийн газар худал мэдээллийг хянах, тараасан этгээдэд хариуцлага тооцох хатуу хуулиудтай. WeChat, Weibo зэрэг платформууд нь хэрэглэгчдийн нийтэлсэн контентыг хатуу хянадаг. Малайз "Anti-Fake News Act" (2018, цуцлагдсан ч 2021 онд шинэчлэгдсэн) – Худал мэдээлэл тараасан этгээдийг шүүхээр шийтгэдэг байсан ч сөрөг шүүмжлэл ихэссэний улмаас хуульд өөрчлөлт оруулсан. Инденоз Цахим мэдээлэл, дамжуулалтын тухай хууль (ITE Law) Олон нийтийг төөрөгдүүлэх мэдээлэл тараавал эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой.

Гэх мэтчилэн цахим орчин дахь худал мэдээллийг хянах нь улс орон бүрийн бодлого, хуулийн зохицуулалтаас хамаардаг. Зарим улс хатуу хяналт тавьдаг бол зарим нь үүнийг илүү олон нийтийн өөрийн шүүлтээр зохицуулахыг илүүд үздэг Улс орнууд худал мэдээлэлтэй тэмцэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн ба торгууль болон хорих ял, мэдээллийг устгах шаардлага, залруулга нийтлүүлэх, интернетийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад хяналт тавих, мэдээллийн боловсрол олгох бодлого арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Тиймээс олон улс орнууд цахим орчинд худал мэдээлэл (дезинформаци) нийтлэхийг хориглосон хууль, дүрэм журам боловсруулан мөрдөж байна. Хуурамч мэдээлэл нь нийгмийн зөрчил үүсгэх, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэх, иргэдийн итгэлийг алдагдуулах аюултай гэж үздэг тул үүнтэй тэмцэх нь чухалд тооцогддог.

Харин манай улсын хувьд хууль эрх зүйн бүрдсэн боловч хэрэгжилтийн болон хууль хэрэглээний хувьд, иргэдийн цахим орчин буюу олон нийтийн сүлжээний

талаарх ойлголт, боловсрол дутмаг, түүнээс үүсэх эрх зүйн үр дагавар, сөрөг нөлөө, эрсдлийн талаарх нэгдсэн ойлголтгүй байна гэж дүгнэж болохоор байна. Бусад улс орнуудын худал мэдээлэлтэй тэмцэх гол арга хэмжээнүүдийг бүрдүүлснээр цахим орчинд хуурамч мэдээлэл тархах эрсдлийг бууруулж, нийгмийн тогтвортой байдал, мэдээллийн үнэн зөв байдалд анхаарч ажиллах шаардлагатай юм.

ДҮГНЭЛТ

Мэдээлэл, технологи хурдацтай хөгжихийн зэрэгцээм “шинэ” харилцааг бий болгож байна. Үүний илрэл нь цахим мэдээлэл, харилцаа, орчин, орон зайг бий болгож байгаа явдал юм. Сүүлийн жилүүдэд дэлхий даяар иргэдийн мэдээлэл олж авах, харилцаа холбоо тогтоох боломж нь маш их нэмэгдсэн хэдий ч, зарим хүмүүсийн хувьд мэдээлэл олж авах боломж нь тун хязгаарлагдмал байдаг бол бусад нь хэвлэл мэдээлэл, шууд нэвтрүүлэг болон бусад дижитал хэлбэрээр хангалттай мэдээллээр хангагдаж байна. “Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол” нь цахим, цахим бус орчныг хэрхэн зүй зохистой ашиглах, мөн аливаа мэдээлэлд хэрхэн шүүмжлэлтэй хандаж дүгнэх вэ? Цахим болон цахим бус орчин дахь бидний эрх үүрэг юу вэ? Мэдээлэл олж авах, ашиглахтай холбоотой ёс зүйн асуудлууд юу вэ? Эрх тэгш байдал, соёл, шашин хоорондын хамтын ойлголцол, энх тайван, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэл олж авах эрх зэргийг хөхиүлэн дэмжихэд хэвлэл мэдээлэл болон мэдээлэл, харилцаа холбооны технологийг хэрхэн ашиглах талаарх зохицуулалт шаардлагатай болжээ.

Дээрх шаардлагаас улбаалж Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд олон нийтийн сүлжээ ашиглаж аливаа зүйлийг нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх орон зай нэгэнт бүрдсэн. Энэхүү цахим харилцаанд оролцохдоо худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох зүй бус үйлдэл гарах болсноор бусдын эрх чөлөөг хамгаалах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Олон нийтийн сүлжээ ашиглаж худал мэдээ, мэдээлэл тараах бусдыг гүтгэх, доромжлох, нэр төр, алдар хүндэд, халдах хууль бус үйлдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Олон нийтийн сүлжээ ашиглаж худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох, нэр төр, алдар хүндэд халдах хууль бус үйлдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд эрх зүйн арга хэмжээ авагдсаны дотор Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/, Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Иргэний хууль /2002 он/, Хүүхэд хамгаллын тухай /2016/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай /1997/, Сонгуулийн тухай /2015 он/19 зэрэг хуулиуд, Монгол Улсын Их Хурлын тогтоол “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, Засгийн газрын тогтоол “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдан гарсан байна. Монгол Улсад цахим орчин дахь худал мэдээ, мэдээлэл тараах, гүтгэх, доромжлох үйлдэл, түүнд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тодорхой байдлаар хуульчилсан байна гэж дүгнэж болохоор байна.

Гэхдээ хуулиудын уялдаа холбоо, хэрэгжилт тал дээр анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна. Нөгөөтээгүүр юун түрүүнд цахим орчинд худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэж, доромжлох нь өөрөө хууль бус үйлдэл гэдгийг нийгэм, хувь хүнд хичнээн их хор хөнөөл бий болдог, түүнээс учирч болох эсрдэлийн талаар, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар иргэд, олон нийтэд

хандсан уриалга, сургалт, сурталчилгааг зохион байгуулах арга хэмжээ дутагдаж байна.

Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасан “гутаасан мэдээ” нь “худал мэдээлэл” болон “үнэн мэдээлэл”-ийг давхар агуулдаг. Иргэний хуулийн 21.3-т бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол няцаах үүрэг хүлээхээр зохицуулсан. Иргэний хуулиар зохицуулж буй гутаасан мэдээ буюу бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрийг гутаасан бол уг асуудал нь Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт тооцогдох эсэх нь тодорхойгүй байна.

Эдгээр эрх зүйн актууд нь худал мэдээ тараах, бусдын нэр төрд халдаж гүтгэн доромжлох сөрөг үйлдлийг зохицуулах үндэс суурийг тавьсан гэж үзэх үндэстэй. Хэдий тийм боловч нэг талаар хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарах, нөгөө талаар цаг үеийн техник технологийн хурдтай өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан, түүнчлэн олон улсын жишиг, чиг хандлагатай нийцүүлэн “угтах бодлого”-ыг баримтлан үндэсний хууль, тогтоомжоо нийцүүлэн боловсруулах шаардлага тулгарч байна. Олон нийтийн сүлжээ ашиглаж худал мэдээ, мэдээлэл тараах, бусдын нэр төрд халдаж гүтгэх, доромжлох зүй бус үйлдэл нь зөвхөн Монгол орноор хязгаарлагдахгүй дэлхийн улс орны хэмжээнд анхаарал хандуулсан асуудлын нэг болж байна.

Олон улсын хүрээнд авч үзвэл худал мэдээ, мэдээлэл тараах, бусдын нэр төрд халдаж гүтгэх, доромжлох үйлдлийг шууд “цахим орчин дахь гэмт хэрэг мөн, биш” гэдэг үзэл нь маргаантай байгаа хэдий ч хууль бус “буруу” зүйл гэдэг дээр санал нэгтэй байна. Энэ үүднээс уг асуудлыг хуулиар, дүрэм, журмаар эсхүл хувь хүний өөрийнх нь соёлын хэмжүүр болгох уу зэрэг хэрхэн, яаж зохицуулах вэй гэдэг асуудал гардаг байна.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол хүлээн авах, шалгах, шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан журмаар шийдвэрлэгдэх иргэний маргааны шинжтэй бол энэ төрлийн өргөдөл, гомдлыг хүлээн авахгүй байх, уг асуудлаар үүсгэсэн эрүүгийн хэргийг шууд хэрэгсэхгүй болгож байх, цаашид хууль хэрэглээний хувьд Эрүүгийн хуульд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан журмаар шийдвэрлэгдэх хэрэг маргааныг зөв ялган зүйлчлэх, иргэний шинжтэй маргааныг эрүүгийн журмаар шалгахгүй байх, эрүүгийн хариуцлагад татахгүй байх шаардлагатай. Мөн хууль хоорондын ялгаа болох мэдээ, мэдээллийн ялгаатай байдлыг хууль зүйн хувьд тайлбарлан хэрэг маргааныг хянан шийдвэрлэж шүүхийн шийдвэрийг гаргаж чадаагүй байна. Жишээлбэл иргэний хэргийн шүүхийн шийдвэрт иргэний хуулийн 21.2-т заасан “мэдээ” гэх үг ороогүй “мэдээлэл” гэж бичигдэж тайлбарлагдсан байна.

Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэг бол “Хүний халдашгүй, чөлөөтэй байх

эрхийн эсрэг гэмт хэрэг”-ийг хуульчилсан. Гэтэл хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах

ял шийтгэнэ.”гэж зааснаас үзвэл хуулийн этгээдийн нэр хүндийг хуульчилсан нь хууль тогтоомжийн тухай хуулиар зөрчилтэй байна. Тодруулбал Монгол Улсын Үндсэн хуульд халдашгүй чөлөөтэй байх нэр төр, алдар хүнд халдашгүй чөлөөтэй байх эрхийг Монгол Улсын иргэнд баталгаатай эдэлнэ гэж баталгаажуулсан. Субьектийн хувьд ялгаатай атал хууль тогтоож түүний харгалзан үзээгүй байна. Үүнтэй адил эрүүгийн хэргийн шүүх хуулийн этгээдийн нэр төрд халдсан хэрэг маргааны хянан шийдвэрлэж эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

1. Эрүүгийн болон Иргэний шүүх нь хуульд заасан мэдээ болон мэдээлэл хэмээх ойлголтыг хамтат нэг ойлголт мэтээр тайлбарлаж хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн байна. Иймээс Монгол Улсын Дээд шүүхээс Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 14 дэх хэсэг заасан “мэдээлэл”, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дэх хэсэгт заасан “...мэдээ...” талаарх нэр томьёоны тодорхойлолт гаргах шаардлагатай байна.

2. Эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн практикаас харвал шүүх болон шүүгч нар Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийг эрүүгийн хуулиас хасах шаардлагагүй гэж үзэж байна. Харин “худал мэдээлэл” хэмээх ойлголтын талаарх өөр өөр тодорхойлолтоор хэрэг маргааныг хянан шийдвэрлэж байх тул энэ талаарх нэр томьёоны тодорхойлолтыг Улсын дээд шүүхээс гаргах шаардлагатай.

3. Иргэд олон нийтэд хэвлэл мэдээллийн анхан шатны боловсрол олгох, цахим хэрэглээ соёлыг төлөвшүүлэх нэн шаардлагатай байна. Үүнийг шат дараатайгаар боловсролын системд нэвтрүүлэх

4. Судалгааны явцад цахим орчин гэсэн ойлголтыг мөн л олон янз байдлаар ашиглаж байна. Жишээлбэл цахим сүлжээ, олон нийтийн цахим сүлжээ, сошиал мэдиа, олон нийтийн сүлжээ, интернетийн сүлжээ, кибер орчин гэх мэтээр янз бүрээр ойлгож байх бөгөөд “цахим орчин” тодорхойлох томьёолж хуульчлах шаардлагатай.

5. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү энэ сарын 10-ны өдөр Кибер аюулгүй байдлын хүрээнд “Худал мэдээлэлттэй тэмцэх төв” байгуулна гэж мэдэгдсэн бөгөөд судлаачийн зүгээс энэхүү саналыг дэмжиж байна. Манай улсад энэ төв байх хэрэгцээ шаардлагатай хэмээн судалгааны явцад дүгнэсэн.

НОМ ЗҮЙ

А. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Монгол Улсын Иргэний хууль 2002 он
3. Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 он
4. Зөрчлийн тухай хууль 2017 он
5. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль 1998 он
6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2021 он
7. Хүний хувийн мэдээллийн хамгаалах тухай хууль 2022 он
8. Иргэний хуулийн тайлбар, 2010 он
9. Герман Улсын Сүлжээний хэрэгжилтийн тухай хууль 2017 он
10. Бүгд Найрамдах Эстони Улсын Эрүүгийн хууль 2011
11. УДШ, Ханнс-Зайделын сан, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010 он
12. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах түүнд хяналт тавих журам 2024

Б. Ном сурах бичиг, гарын авлага

1. Монгол хэлний их тайлбар толь
2. Ж.Оюунтунгалаг. Иргэний эрх зүй I Ерөнхий анги 2020 он
3. Монгол, Орос, Хятад, Герман улсуудын Эрүүгийн хууль, МУИС-ийн ХЗС, орчуулсан Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Батбаяр, Т.Золбоо 2021 он
4. Ц.Ган-Оч, Б.Доньжчимбуу, Мэдээллийн эрх зүй, 2019 он
5. С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, Ерөнхий анги 1996 он
6. ОХУ-н судлаач эрдэмтэн С.В.Михайлович “Условия, способы гражданско правовой зашиты чести, достоинства и деловой репутаци” бүтээл 2006 он

В. Судалгааны тайлан

1. “Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХК-н “Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг цахим хуудсыг хаах замаар хязгаарлах арга хэмжээний зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ” судалгаа УБ.,2024
2. Нээлттэй нийгэм форум “Худал мэдээлэл тараах шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ” судалгааны тайлан 2023 он
3. Глоб интернейшнл төв, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2023 он
4. Хууль зүйн үндэсний хүрээлэн “Цахим орчин дахь хүнийг эрхийг хамгаалах асуудал” судалгааны тайлан 2022 он
5. “Глоб интернейшнл ТББ, Олон нийтийн мэдэх эрх: мэдээллийн эрх чөлөө 2002

он
6. Харилцаа холбооны зохицуулах хороо “Цахим орчны зохицуулалт зөвлөмж” 2021 он
7. UNESCO, Дисинфодемик буюу хуурамч мэдээллийн цар тахал (Ковид 19-тэй холбоотой хуурамч мэдээллийг ухаж ойлгох нь), Бодлогын хураангуй, Орчуулсан Глоб интернэшнл төв, 2021 он
8. НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (№34, 19 дүгээр зүйл, 2011)Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө.
9. Ш.Сүхбаатар Шинжлэх Ухааны Академийн Мэдээ №03 (197) 50 тал “Хүний заяагдмал эрхийн салшгүй хэсэг болох нэр төр, алдар хүндийн тухай ойлголтын судалгаа 2010 он

Г. Бусад

1. МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш Г.Мэндхүүгийн ярилцлагаас
2. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020.02.13, №07 (1109), http://parliament.mn/n/wzmy
3. Statista, Number of internet and social media users worldwide as of April 2024 https://www. statista.com/statistics/617136/digital-population-worldwide/
4. https://datareportal.com/reports/digital-2024-mongolia
5. Benhadj v. Algeria, 1173/2003 дугаартай гомдолд холбогдох 2007 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дүгнэлтийг үзнэ үү. Park v. Republic of Korea, No. 628/1995 дугаартай гомдолд холбогдох 1996 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн дүгнэлт
6. Council of Europe., Legal instruments., Recommendation CM/REC 13 (2022), The Impacts of Digital Technologies on Freedom of Expression., https://edoc.coe.int/en/international-law/11101-the-impacts-of-digital technologies-on-freedom-of-expression-recommendation-cmrec202213.
7. La Rue, Frank, UN. Human Rights Council, Special Rapporteur on the Promotion and Protection of the Right to Freedom of Opinion and Expression, 2011.05.27, https://digitallibrary.un.org/record/706200
8. https://www.jurist.org/news/2024/06/un-launches-global-principles-to-address-misinformation-disinformation-and-hate speech/?fbclid=IwY2xjawIQDzVleHRuA2FlbQIxMAABHQz4ceE-098ksrx5Zsg7MRgu4 2BPnpWF_oAOvwAyCCPmeBigQ90jYlPLQ_aem_UKvtOcPX2xsotzyLdDgUFg
9. Онлайн контентын танилцуулга, https://crc.gov.mn/list/internetijn-s-lzhee-jlchilgee/mn
10. Нийтлэлч С.Уянга Fake news нийгэмд ямар хор “шахдаг” вэ? нийтлэл https://www.polit.mn/a/104927
11. Based on their definition under Article 1(1)(aa) of the AVMSD, video-sharing platform services may be identified on the basis of the following three criteria:

12. Freedom on the Net: Estonia, The Freedom House, 2022, https://freedomhouse.org/country/estonia/freedom-net/2022#footnote8_ld4ljal

ХАВСРАЛТ

№1 ИРГЭН “Н”-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААСАН” ГЭМТ ХЭРЭГ

Шүүх: Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүхийн шийдвэрийн он сар дугаар: 2024 оны 01 сарын 12 өдөр Дугаар 2024/ШЦТ/05

Товч агуулга: Шүүгдэгч “Н” нь 2023 оны 07 дугаар сараас 24-ний өдөр Завхан аймгийн Нөмрөг сумын фейсбүүк цахим групп дээр Ganaa Ganchimeg гэсэн хаягаас “Энэ нэг Яанхан хүүхэн хэдэн жил сум оронд минь байж хүн хүний эр нөхөртэй заваарах юм бэ шөнө байж ядах юм нөхөр сүүдэр амраахгүй юм архи ууя гараад ир шоудна гээд олон дуугай байлаа зайлаад өгөөч хүн харахад гэмгүй юм шиг яанхан юмаа, ажлын байрандаа ч архи ууна ах дүү нь хэлж хийх хүн байвал хэлээрэй эхний удаа ингэж олонд түгээе дараагийн удаа өөр шүү” гэсэн мэдээлэл хохирогчийн зургийн хамт тавьсан, түүнээс хойш “Zawtain zalgaarai belen bna 80822906 duudlagaar untana ene ya”, “gai mini zailchih mongo awj hanaj bnuu”, “яанхан минь шөнө орой гэр бүл тайван байлгаад өгөөч чи” зэрэг мэдээллийг хохирогч *******ийн зургийн хамт тавьж нэр төрд халдсан, илт худал мэдээллийг олон нийтэд удаа дараа тараасан гэмт хэрэгт холбогдож. Шүүгдэгч “Н” нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч *******г Завхан аймгийн Нөмрөг сумын төвийн нутаг дэвсгэрээс 2 /хоёр/ сарын хугацаагаар гадагш зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэжээ.

Дүн шинжилгээ: Шүүгдэгч ******* нь ээжийнхээ ашигладаг 98466444 дугаарыг ашиглаж “Ganaa Ganchimeg” гэсэн нэртэй фейсбүүк хаяг нээж, уг фейсбүүк хаягаас 2023 оны 07 дугаар сараас 24-ний өдөр Завхан аймгийн Нөмрөг сумын фейсбүүк цахим групп дээр “Энэ нэг яанхан хүүхэн хэдэн жил сум оронд минь байж хүн хүний эр нөхөртэй заваарах юм бэ шөнө байж ядах юм нөхөр сүүдэр амраахгүй юм архи ууя гараад ир шоудна гээд олон дуугай байлаа зайлаад өгөөч хүн харахад гэмгүй юм шиг яанхан юмаа, ажлын байрандаа ч архи ууна ах дүү нь хэлж хийх хүн байвал хэлээрэй эхний удаа ингэж олонд түгээе дараагийн удаа өөр шүү” гэсэн мэдээлэл хохирогч *******ийн зургийн хамт тавьсан, түүнээс хойш “Zawtain zalgaarai belen bna 80822906 duudlagaar untana ene ya”, “gai mini zailchih mongo awj hanaj bnuu”, “яанхан минь шөнө орой гэр бүл тайван байлгаад өгөөч чи” зэрэг мэдээллийг хохирогч
*******ийн зургийн хамт тавьж, нэр төрд халдсан, илт худал мэдээллийг олон нийтэд удаа дараа тараасан **болох нь** шүүх хуралдаанд хийсэн ...Turshilt гэсэн фейсбүүк

хаягийг нээгээд утасны дугаарт шүүгдэгчийн 98117189 гэсэн дугаарыг оруулаад үргэлжлүүлэхэд шүүгдэгчийн 98117189 дугаарт мессежээр код гэж 57994 дугаар ирэхэд уг дугаарыг оруулахад turshilt гэсэн нэртэй фейсбүүк хаяг нээгдсэн туршилт, хохирогч *******ийн “...Баасандаш эгч 98466444 дугаарыг нь олж өгөөд, дугаараар нь хайхад үхэр алдсан гэх зар гарч ирсэн. Тэгэхэд *******гийн фейсбүүк хаягаар пост оруулсан байсан. 98466444 дугаарыг хэн эзэмшдэгийг мэдэхгүй байсан...” гэсэн мэдүүлэг, мөрдөгчийн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн “...98466444 дугаарыг Фейсбүүк хаягт хийж хайлт хийхэд “Ganaa Ganchimeg” нэртэй фейсбүүк хаяг гарч ирсэн тул гэрэл зургаар бэхжүүлэн авч хэрэгт хавсаргав...” гэсэн тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлтээр тус тус нотлогдож байна гэж шүүх дүгнэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн нь “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх ... эрхтэй” бөгөөд гагцхүү энэхүү эрх нь Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэх” үүргээр хязгаарлагдана. “Олон нийтэд тараасан” гэж худал мэдээллийг нэг буюу түүнээс олон хүнд түгээсэн байхыг ойлгох бөгөөд мэдээллийг амаар, бичгээр, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчны аль алинаар нь тарааж болно. Худал мэдээлэл тараах гэмт хэрэг нь гэмт этгээд нь хохирогч руу шууд чиглэн түүний хувийн болон ёс зүй, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, эрүүл мэнд, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, гадна төрх, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдалтай нь холбогдуулан илт худал мэдээллийг санаатайгаар олон нийт буюу бусдад тарааж ярьснаар төгсдөг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй юм хэмээн дүгнэж шийдвэрлэжээ.

Энэхүү шүүхийн шийдвэрээс дүгнэвэл Гэр бүлээс гадуурх харилцаа, гэр бүлийн гишүүдийн хэрүүл маргаан, хардалтаас үүсэлтэйгээр гуравдагч этгээдийн нэр төр, алдар хүндийг зүй бусаар доромжлон гутаасан үйлдлийг шүүгчдэгч нь уурлан хорсож, хэд хэдэн үйлдлээр 2 ба түүнээс дээш фэйсбүүк группэд нийтэлжээ. Шүүхийн практикт “худал мэдээлэл” хэмээх ойлголтод “доромжлох”, “гүтгэх” агуулгыг хамааруулж үзэж хэргийг шийдвэрлэсэн шүүхийн практик тогтсон байна.

№2 ИРГЭН “Б.Э”-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААСАН” ГЭМТ ХЭРЭГ

Шүүх: Дорноговь аймгийн замын-үүд сум дахь сум дундын шүүхийн

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2024 оны 04 сарын 22 өдөр Дугаар 2024/ШЦТ/43

Товч агуулга: Шүүгдэгч Б.Э нь нөхөр Б.М-ыг З.Ч-тай гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэсэн гэх шалтгааны улмаас хардаж 2023 оны 11 сарын 14-нөөс 2023 оны 11 сарын 15-нд шилжих шөнө “...” гэх хуурамч фейсбүүк хаяг нээж З.Чын ашигладаг “...” гэх нэртэй фейсбүүк цахим хаягаас зургийг нь авч “... хамгийн том зар, мэдээлэл”, “... ачаа тээвэр-такси-бараа хүргэлт”, “... замын ажилчдын нэгдсэн групп”, “... нэгдсэн зар, мэдээлэл” гэх нэртэй фейсбүүкийн зарын группүүдэд “Exnertei huuhedtei xvntei zawaar ch ger bvl salgahaa bol buzraa” /эхнэртэй хүүхэдтэй хүнтэй заваарч гэр бүл салгахаа боль бузраа/ гэж бичиж зургийг нь тавьж нэг төр, алдар хүндэд халдсан, илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэгт холбогджээ.

Гэмт хэрэг гарах болсон шалтгаан нөхцөл, хохирогчид учруулсан хор уршийг харгалзан үзээд шүүгдэгчид 1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох торгуулийн ялыг оногдуулжээ. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1, 511 дүгээр зүйлийн 511.3-т зааснаар шүүгдэгч Б.Э-с /2,744,500+105,100/ 2,849,600 төгрөгийг гаргуулж хохирогч З.Ч-д олгохоор шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ: Шүүгдэгч Б.Э шүүх хуралдаанд өгсөн мэдүүлэгтээ: 2021 онд М-тай хамт явсан байсан юм. Манай нөхөртэй яваад байна гэдгийг би хүмүүсээс сонсож байсан боловч манай нөхөрөөр үйлчлүүлдэг хүн байх гэж бодсон юм. Тэгээд нэг өдөр ахтайгаа утсаар ярих гээд нөхрийн утсыг оролцож байтал манай нөхөр Ч-тай харилцаатай байсан. Манай нөхөр шорлог идэх үү, Ч бас шорлог идэх үү гэх зүйлийг бичсэн, мөн бие биенийхээ зураг дээр лайк, зүрх дарах, шейр хийх зэрэг үйлдлийг хийсэн байсан. Би Ч, нөхөр хоёртой энэ харилцаагаа боль гэж хэлэхэд огт тоохгүй байгаад байсан болохоор нь уур хүрээд цахим сүлжээнд тавьсан юм. Буруу зүйл хийсэн гэдгээ ойлгож байгаа, хохирлыг төлж барагдуулна гэжээ.

Шүүгдэгч Б.Э нь “...” гэх хуурамч фейсбүүк хаяг нээж хохирогч З.Ч-ын ашигладаг “...” гэх нэртэй фейсбүүк цахим хаягаас зургийг нь авч “...”, “...”, “...”, “...” гэх нэртэй фейсбүүкийн зарын группүүдэд “Exnertei huuhedtei xvntei zawaar ch ger bvl salgahaa bol buzraa” /эхнэртэй хүүхэдтэй хүнтэй заваарч гэр бүл салгахаа боль бузраа/ гэсэн илт худал мэдээллийг тавьж түүний зургийн хамт тавьснаар хохирогчийн хуулиар хамгаалагдсан нэр алдар хүндэд халдаж буй гэмт хэргийн шинжийг бүрэн хангаж байна гэж шүүх дүгнэв. Шүүгдэгчийн дээрх үйлдэл нь Эрүүгийн хуулийн ерөнхий

ангийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсэж үйлдсэн, хохирол хор уршигт зориуд хүргэсэн бол санаатай гэмт хэрэгт тооцно” гэж зааснаар гэм буруугийн санаатай хэлбэртэй, хүний нэр төр, алдар хүндэд халдах, гутаах зорилготой байна.

Энэхүү шүүхийн шийдвэрээс дүгнэвэл Гэр бүлээс гадуурх харилцаа, гэр бүлийн гишүүдийн хэрүүл маргаан, хардалтаас үүсэлтэйгээр гуравдагч этгээдийн нэр төр, алдар хүндийг зүй бусаар доромжлон гутаасан үйлдлийг шүүгчдэгч нь уурлан хорсож, хэд хэдэн үйлдлээр 2 ба түүнээс дээш фэйсбүүк группэд нийтэлжээ. Шүүхийн практикт “худал мэдээлэл” хэмээх ойлголтод “доромжлох”, “гүтгэх” агуулгыг хамааруулж үзэж хэргийг шийдвэрлэсэн шүүхийн практик тогтсон байна.

№3 ИРГЭН Ц-ГИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Шүүх: Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Шүүхийн шийдвэрийн он сар дугаар: 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Дугаар 2020/ШЦТ/98

Товч агуулга: Т.Ц нь фейсбүүкийн “С зар” гэх бүлэг дээр “Т... Т...” гэх фейсбүүк хаягаас иргэн Э, Д нарын зургийг оруулаад түүнийхээ дор “...гэр бүл салгаж, ажил дээрээ явалддаг ...дүгээр цэргийн ангийн албаа хаагчид” гэсэн пост оруулсан нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан” илт худал мэдээллийг олон нийтэд тараасан учир ЭХТА-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогджээ. Шүүхээс 500,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ.

Дүн шинжилгээ: Шүүгдэгч Т.Ц хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, тэрээр өөрөөс нь мөнгө зээлээд өгөхгүй байсан Э-рүү гар утсаараа удаа дараа залгасан боловч Э нь утсаа авахгүй зугтаж, харин өмнөөсөө Д-ээр утсаа авхуулж Д нь “...мөнгө өгөхгүй, чи мэдрэл муутай гээ биз дээ, шар хаданд очиж эмчлүүл” гэсэн доромжлол хэлсний хариуд дээрх байдлаар фэйсбүүк хуудаснаа худал мэдээлэл тараажээ. Шүүх шийтгэх тогтоолдоо “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан нь хавтаст хэрэгт цуглуулж бэхжүүлсэн баримтуудаар нотлогдсон, шүүгдэгч Т.Ц-гийн гэмт үйлдлийн улмаас албан байгууллага, хувь хүнд материаллаг хор уршиг учруулаагүй боловч тэдний нэр төр, алдар хүндийг гутаасан, доромжилсон үйлдэл болсон бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг нь материаллаг хор уршиг шаардахгүй юм” гэжээ. Гэрч Д.Б мэдүүлэхдээ “2020 оны 3 дугаар сард манай байгууллагын нэр бүхий хоёр алба хаагчдын фейсбүүк хаягийн зургийг “С зар” группт байршуулан тайлбар хэсэгт нь “Гэр бүл салгаж ажил дээрээ явалддаг ...дүгээр ангийн алба хаагчид” гэсэн утгатай мэдээллийг оруулсан явдал нь алба хаагчдын болон анги байгууллагын өгсөн үүргийн дагуу албан бичиг, өргөдөл, гомдлыг Захиргаа, хүний нөөцийн тасгийн дарга, дэд хурандаа Э-гийн хамт Цагдаагийн газарт өгсөн. Тухайн мэдээллийг фэйсбүүк цахим сүлжээнд орсон даруйд нь манай байгууллага цагдаагийн байгууллагад шалгуулахаар хүлээлгэн өгсөн юм. Түргэн шуурхай арга хэмжээ авсан болохоор манай байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдаагүй” гэжээ. Гэрч Т.Ч мэдүүлэхдээ “Тухайн этгээд тус зарыг оруулахдаа хилийн ...дүгээр ангийн нэр хүндэд халдаж, нийгэмд буруу ташаа мэдээлэл тараасан гэж үзэж байна. Тус алба хаагчид нь тус тусын гэр бүл, үр хүүхэдтэй хэвийн тогтуун амьдралтай. Тухайн зарыг оруулсан этгээдэд хуулийн дагуу хариуцлагыг хүлээлгэмээр байна” гэжээ. “Гэр бүл салгаж ажил дээрээ явалддаг ...дүгээр ангийн алба хаагчид” гэсэн утгатай мэдээлэлд төрийн байгууллага өргөдөл, гомдол гаргасан нь анхаарал татаж байна. Энэ нь төрийг үл хүндэтгэх, төр, түүний байгууллагын нэр хүндийг гутаасан, доромжилсон, төрийн нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараасан иргэнийг буруутгах үзэл баримтлалын илэрхийлэл юм. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд

“Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол” гэмт хэрэгт тооцохоор заасан нь хуулийн этгээдийн нэр хүндэд халдсан иргэнийг буруутгах үндэслэл болж байна. Нэр хүндэд халдсан гэдэг нь заавал гутаасан гэсэн агуулгыг бүрэн илэрхийлэхгүй бөгөөд харин нэр хүнд нь хөндөгдсөн бол халдсан гэж гомдол гаргаж болох үндэслэлтэй болжээ. Иргэн Б-гийн үйлдэл нь хувийн харилцаанаас үүссэн, бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан хэрэг юм. Иргэн Б буруу зүйл хийсэн гэдгээ ойлгож, оруулсан мэдээллээ 40 минутын дараа устгасан байдаг. Цаашид ийм агуулга бүхий маргааныг эрүүгийн гэмт хэрэгт тооцож ял шийтгэл оногдуулахаас илүүтэйгээр иргэний хуулиар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэхээр байна.

№4 ИРГЭН “Ц.С”ИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Шүүх: Өмнөговь аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /эрүүгийн хэрэг/ийн шийтгэх тогтоол

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2023 оны 01 сарын 02 өдөр, Дугаар 2023/ШЦТ/06

Товч агуулга: Шүүгдэгч Ц.С нь 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Өмнөговь аймгийн Булган сумын 4 дүгээр баг, Халгайтын 4-10 тоот гэртээ байхдаа хохирогч О.Эыг нөхөр Бтэй хардсаны улмаас “Zaya Zaya” гэх фейсбүүк хаягнаас хохирогч О.Эы зургийг ашиглан “Ханбогд зар /Han bogd zar/ нэгдсэн групп” фейсбүүкийн пэйж дээр “Ene ynhaniig tanih u oyutolgoi ni ynhan oyutolgoi chini yanhanii gazar ym uu” гэх постыг “Ханбогд шуурхай зар” фейсбүүкийн пэйж дээр “Oyutolgoi ajilladag E gej ynhanaas bolgoomjil ail ger vimuuledeg ichihgui 2 huuhedtei bj bugsuur hooloo olj iddeg” гэх постыг тус тус оруулж, хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэх гэмт хэрэгт холбогджээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Ц.Сд 450 /дөрвөн зуун тавь/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 450.000 /дөрвөн зуун тавин мянга/ төгрөгөөр торгож шийтгэжээ.

Шүүхийн шийтгэх тогтоолд “…**алдар хүнд…”** гэдэгт бусдаас өөрийнх нь талаар өгсөн үнэлгээнд тулгуурлан өөртөө өгсөн тухайн хүний үнэлэмжийг ойлгоно.

“…доромжлох …” гэдэгт нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон ёс суртахууны шаардлагын хэм хэмжээ, үндэсний зан заншил, уламжлалд харшилсан, тухайн хүний нэр төр, алдар хүндийг санаатай гутаасан үйлдлийг хэлнэ.

Энэ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, эрүүл мэнд, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, гадна төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр гутаасан зэргээр илэрнэ.

Мөн “…**олон нийт**…” гэдэг нь нийгмийн нэг хэсгийг тодорхойлсон ойлголт учир тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бий болгох нөхцөлийн хувьд заавал хоёр буюу түүнээс олон хүний дэргэд доромжилсон байхыг шаардахгүй бөгөөд бусдын нэр төр, алдар хүндийг нэг хүний ч дэргэд гутаасан байж болно.

“…**хэвлэл мэдээллийн хэрэгсэл**…” гэдгийг зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д зааснаар ойлгохоор тайлбарлажээ.

Шүүгдэгч Ц.С нь 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Өмнөговь аймгийн Булган сумын 4 дүгээр баг, Халгайтын 4-10 тоот гэртээ байхдаа хохирогч О.Эыг нөхөр Бтэй хардсаны улмаас “Zaya Zaya” гэх фейсбүүк хаягнаас хохирогч О.Эы зургийг ашиглан “Ханбогд зар /Han bogd zar/ нэгдсэн групп” фейсбүүкийн пэйж дээр “Ene ynhaniig tanih u oyutolgoi ni ynhan oyutolgoi chini yanhanii gazar ym uu” гэх постыг “Ханбогд

шуурхай зар” фейсбүүкийн пэйж дээр “Oyutolgoi ajilladag E gej ynhanaas bolgoomjil ail ger vimuuledeg ichihgui 2 huuhedtei bj bugsuur hooloo olj iddeg” гэх постыг тус тус оруулж, хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан болох нь хэрэгт авагдаж шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судалсан нотлох баримтуудаар хөдөлбөргүй тогтоогдож байна.

Шүүгдэгч Ц.С нь үйлдсэн гэмт хэргээ хүлээн мэдүүлсэн мэдүүлэг, Өмнөговь аймгийн Прокурорын газарт гаргасан “Ц.С би О.Эы талаар цахим орчинд худал мэдээлэл тараасан гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрч байна. Хохирогч О.Э хохирол төлбөр нэхэмжлээгүй тул хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж өгнө үү” гэх хүсэлт /хавтаст хэргийн 74 дэх тал/ зэрэг нотлох баримтаар шүүгдэгч Ц.С гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөржээ.

Энэхүү шүүхийн шийдвэрээс үзвэл иргэний эрх зүйн боловсрол мэдлэг дутмаг, сэтгэл хөдлөлөөр хандаж хуулиар хамгаалагдсан иргэний баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөнд халдсан байна. Энэ мэт агуулгатай пост нийтлэлийг иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө хэмээх нь хууль ёс суртахууны хэм хэмжээнд нийцэхгүй юм.

№5 ИРГЭН “С.М”ИЙН “ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ” ГЭМТ ХЭРЭГ

Шүүх: Төв аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /эрүүгийн хэрэг/ийн шийтгэх тогтоол

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2024 оны 03 сарын 11 өдөр, Дугаар 2024/ШЦТ/88

Товч агуулга: Яллагдагч С.М нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэмт хэрэгт холбогджээ.

Эрүүгийн дугаартай хэрэгт гэмт хэрэгт хамааралтай, ач холбогдолтой гэж цуглуулж, бэхжүүлж авсан бичгийн нотлох баримтуудаас шүүгдэгч С.Мын 2023 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр "Лүн сумын 2 дугаар багийн нутаг "Гүүрний ам" гэх газарт үйл ажиллагаа явуулдаг “Э" ХХК нь "... махаа газар чирч оруулдаг, махаа бүтээлгээр бүтээдэггүй, ...Лүн сумын тамгын газраас "Э" ХХК-д 8-9 га газар илүү өгсөн, "Э" ХХК-д ажиллаж байсан хүнийг зодож цохиод алсан, тархи нь газраар гоожоод хар уутанд хийгээд бордоо хийсэн. Лүн сумын иргэдийг хөөдөг..." гэх агуулга бүхий зүйл ярьж live бичлэг хийж өөрийн "Иргэдийн төлөөлөгч Ц.М" нэртэй цахим фэйсбүүк хаягт байршуулан олон нийтэд түгээж хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан, илт худал мэдээллийг тараасан хэрэгт холбогджээ.

Шүүх шүүгдэгч С.Мыг долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 700.000 /долоон зуун мянга/ төгрөгийн торгох ялаар тогтоож шийдвэрлэлээ.

Дүн шинжилгээ: Шүүгдэгч С.М нь гэм буруу болон хэргийн зүйлчлэлийн талаар маргадаггүй бөгөөд түүний гэм бурууга хүлээн зөвшөөрсөн мэдүүлэг нь гэмт хэргийн талаар амаар болон холбоо, мэдээллийн хэрэгслээр гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авсан тухай тэмдэглэл, шинжээчийн дүгнэлт, хохирогч, гэрчүүдийн мэдүүлэг болон бусад бичгийн нотлох баримтаар давхар нотлогдож байх тул дээрх нотлох баримтуудыг шийтгэх тогтоолын үндэслэл болгон шийдвэрлэлээ. Шүүгдэгч С.Мын холбогдсон тухайн гэмт хэрэг нь энэ хуулийн тусгай ангийн Арван гуравдугаар бүлэгт заасан “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг” гэмт хэрэгт хамаарах бөгөөд энэ бүлэгт заасан гэмт хэргүүдэд хүний халдашгүй байх эрхийг хуулиар хамгаалж өгсөн ба тухайн эрх нь зөрчигдсөн, хохирол, хор уршиг учирсныг гэмт хэрэгт тооцохоор тусгайлан заасан ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилж өгсөн. Илт худал мэдээлэл гэдэг нь “огт үндэслэлгүй, худал хуурмаг мэдээлэл баримтыг” ойлгодог. Түүнчлэн хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн энр хүндийн талаар энэ үнэлэмжийг илт худал мэдээллээр олон нийтэд гутаан доромжилсон, унагасан, халдсан үйлдлийг ойлгоно гэж үзжээ.

Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэг бол “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”-ийг хуульчилсан. Гэтэл хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх

хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”гэж зааснаас үзвэл хуулийн этгээдийн нэр хүндийг хуульчилсан нь хууль тогтоомжийн тухай хуулиар зөрчилтэй байна. Тодруулбал Монгол Улсын Үндсэн хуульд халдашгүй чөлөөтэй байх нэр төр, алдар хүнд халдашгүй чөлөөтэй байх эрхийг Монгол Улсын иргэнд баталгаатай эдэлнэ гэж баталгаажуулсан. Субьектийн хувьд ялгаатай атал хууль тогтоож түүний харгалзан үзээгүй байна. Үүнтэй адил эрүүгийн хэргийн шүүх хуулийн этгээдийн нэр төрд халдсан хэрэг маргааны хянан шийдвэрлэж эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр байна.

№1 ЭДИЙН БУС ГЭМ ХОРИГ АРИЛГАХ /НЭР ТӨР, АЛДАР ХҮНД, АЖИЛ ХЭРГИЙН НЭР ХҮНДИЙГ ГУТААСАН/

Шүүх: Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

Шүүхийн шийдвэрийн он сар дугаар: 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 210/МА2022/01340 дугаар магадлал.

Товч агуулга: Иргэн А нь хариуцагч Ж, Л нарт холбогдуулан нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг сэргээлгэх, мэдээ тараасан хэлбэр, хэрэгслээр няцаалт хийхийг даалгах, эдийн бус гэм хорын хохиролд 50,000,000 төгрөг гаргуулах, цаашид нэр төрд халдсан үйлдэл гаргахгүй байхыг даалгах тухай нэхэмжлэл гаргасан.

Хариуцагч Ж, Л нар нь нэхэмжлэлийг эс зөвшөөрч “иргэн А-тай холбоотой хэвлэмэл хуудас тараасан нь үнэн, гэхдээ энэ нь түүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан мэдээлэл агуулаагүй” гэж тайлбарлажээ.

Дүн шинжилгээ: Анхан шатны шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Тус шийдвэрийг нэхэмжлэгчийн өмгөөлөгч эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан.

Хариуцагч Ж, Л нар нь 2019.10.27-ны өдөр Монголын Хуульчдын холбооны 4-р Их хурлын завсарлагаанаар “иргэн А, Б нар нь хуйвалдан, хууль бусаар өвлөх эрхийн гэрчилгээ олгосон, ийм хариуцлагагүй, шударга бус хуулиа мэддэггүй, ёс зүйн наад захын шаардлага хангахгүй этгээд тус холбооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байна” гэх агуулга бүхий мэдээлэлтэй хэвлэмэл хуудсыг хурлын төлөөлөгчдөд тараажээ.

Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой маргаанд мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлох үүрэг хүлээдэг ба хариуцагч Ж, Л нар нь дээрх агуулга бүхий мэдээний үнэн, зөвийг нотолж чадаагүй байна. Өөрөөр хэлбэл, хариуцагч Ж, Л нар нь иргэн А-ийн талаар өөрийн санал бодлоо илэрхийлэх эрх нь нээлттэй боловч тэдгээрийн үзэл бодол, сэтгэгдлээ илэрхийлж буй хэлбэр нь бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан агуулгатай байх учиргүй юм.

Давж заалдах шатны шүүх хариуцагч Ж, Л нарыг иргэн А-ийн талаар Монголын Хуульчдын холбооны 4 дүгээр Их хурлын төлөөлөгчдөд тараасан мэдээнийхээ үнэн зөвийг нотолж чадаагүй гэж дүгнэн, иргэн А-ийн нэр төрийг сэргээж, нэхэмжлэлийг энэ хэсгээр хангаж, Монголын Хуульчдын холбооны албан ёсны цахим хуудсаар няцаалт хийхийг хариуцагч Ж, Л нарт даалгаж, нэхэмжлэлээс үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Энэхүү шийдвэрээс үзвэл Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой маргаанд мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлох үүрэг хүлээдэг хэрэв нотлож чадаагүй бол хуулийн хариуцлага хүлээх үндэс болж байна.

№2 ЭДИЙН БУС ГЭМ ХОРИГ АРИЛГАХ /НЭР ТӨР, АЛДАР ХҮНД, АЖИЛ ХЭРГИЙН НЭР ХҮНДИЙГ ГУТААСАН/

Шүүх: Монгол Улсын Дээд шүүх /иргэний хэргийн танхим/

Шүүхийн шийдвэрийн он сар дугаар: 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр 001/ХТ2024/00056

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулан, нэхэмжлэгчийн төлөөлөгч болон өмгөөлөгчийн гомдлыг хангасан.

Товч агуулга: Нэхэмжлэгч “С” ХХК нь “...Э нь 2023.06.27-ны өдөр тавилга хийлгэхээр тохиролцсон, ...захиалгын дагуу зураг төслийг үзүүлж, түүний зөвшөөрснөөр тавилга хийгдсэн, гал тогооны, үүдний болон хүүхдийн өрөөний шкаф гээд нийт 12,824,000 төгрөгийн тавилга хийсэн бөгөөд үүнээс хүүхдийн өрөөний 4,306,000 төгрөгийн үнэтэй шкафыг таалагдахгүй байна гэж буцаалт хийлгүүлж, бусад тавилгыг хүлээн авсан. Гэтэл захиалагч нь манай компаниас илүү мөнгө нэхэж, энэ нэхэмжилсэн мөнгийг өгөхгүй бол танай байгууллагын нэр хүндэд халдана гэж сүрдүүлж эхэлсэн. 2023.08.10-аас эхэлж янз бүрийн сөрөг постуудыг өөрийнхөө Э гэсэн фейсбүүк хаягаас олон нийтэд түгээж эхэлсэн. Сүүлд хийсэн 19-ний өдрийн нийтлэлийг нь 22 хүн үзэж, 34 сөрөг сэтгэгдэл бичигдэж, 6 удаа хуваалцсан, ...энэ нь манай компани руу чиглэсэн гэдгийг олон нийт мэдсэн ба дээрх 34 сөрөг сэтгэгдлээс үзэхэд ажил хэргийн нэр хүндэд халдаж байна...” гэсэн агуулгаар үндэслэлээ тайлбарлаж, компанийн нэр хүндийг гутааж, олон нийтээр шүүлгэн жигшүүлэх зорилгоор хууль бусаар, худал ташаа мэдээлэл түгээсэн буруутай этгээд болох Э-р мэдээлэл тараасан арга хэрэгсэл, хэлбэрээр уучлалт гуйхыг даалгахаар нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Хариуцагч Э нь нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч, “...өөрийн ашигладаг Э гэсэн фейсбүүк цахим хуудсаар нэхэмжлэгч ”С” ХХК-д хандаж мэдээлэл тавьсан. Гэхдээ ”С” ХХК гэж нэрийг нь огт бичээгүй. Сөрөг сэтгэгдэлд хариу өгөөгүй. Харин ”С” ХХК-ийг хурдан хугацаанд тавилгаа засаж янзлаад өгөх байх гэсэн зорилготойгоор өөрийн фейсбүүк цахим хуудсаар мэдээлэл тавьсан, миний буруу байхгүй, чанаргүй тавилга хийж өгсөн, одоо учраа олсон...Уучлалт гуйх үндэслэлгүй” гэсэн агуулгатай тайлбар гаргаж, маргасан байна.

1.Анхан шатны шүүхээс “...хариуцагч Э-д нэхэмжлэгч ”С” ХХК нь доголдолтой тавилга нийлүүлсэн гэдэг боловч ажил гүйцэтгэх гэрээний доголдлоо арилгуулахаар шаардах эрх нь нээлттэй байсан буюу гэрээний доголдлын талаар олон нийтэд зайлшгүй нийтлэл хүргэх шаардлагатай, нийтийн эрх ашиг хөндөгдөж болзошгүй нөхцөл байдал тогтоогдохгүй, ...талууд ажил гүйцэтгэх гэрээгээ дүгнэж, улмаар хохирлоо барагдуулах талаараа холбогдох хууль хяналтын байгууллагад мэдүүлэх эрх нь нээлттэй байсаар байтал таарамжгүй харилцаанаас үүдэн олон нийтийн сүлжээнд мэдээлэл тарааж байгаа нь бодит байдалтай нийцээгүй гэж үзэхээр байна” гэсэн дүгнэлт хийж, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2^{2}, 497

дугаар зүйлийн 497.1[3], 511 дүгээр зүйлийн 511.1[4]-д зааснаар нэхэмжлэгч ”С” ХХК-ийн нэр хүндийг гутааж, худал ташаа мэдээлэл тараасан хэлбэр, хэрэгслээр няцаалт хийж, уучлалт гуйхыг хариуцагч Э-д даалгаж шийдвэрлэсэн.

2. Давж заалдах шатны шүүхээс “...Хариуцагч Э-ийн өөрийн фейсбүүк хуудсанд бичсэн сэтгэгдэл, нийтэлсэн зурагнуудад нэхэмжлэгч компанийн болон захирал С-ийн нэрийг дурдаж нийтлээгүй байхад зөвхөн нэг хүний фейсбүүк хаягаас бичсэн коммент сэтгэгдлээр тавилга хийсэн компанийн нэр хүндэд халдсан, худал ташаа мэдээлэл тараасан гэж үзэх боломжгүй юм. Нэхэмжлэгч тал тавилгыг тохирсон хугацаандаа чанарын шаардлага хангасан доголдолгүй бүтээгдэхүүн нийлүүлэх үүргээ биелүүлээгүй, чанарын доголдолтой байсан тавилгын зургууд тавьсан, нэхэмжлэгч доголдолтой байсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн байдлаас дүгнэхэд хариуцагчийг нийтэлсэн нийтлэлийнхээ үнэн зөвийг нягтлаагүй, мэдээллийг тэнцвэртэй хүргэх зарчмыг баримтлаагүй, нэхэмжлэлийн шаардлагын талаар татгалзлаа нотлоогүй, мэдээллүүд нь нэхэмжлэгчийн нэр төрийг гутаасан гэж үзэх боломжгүй, ...цахим хуудсанд байрлуулсан тавилгын зургууд нь бодит байдал дээр чанарын доголдолтой хийгдсэн тавилга мөн болох нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон, харин нэхэмжлэгч “С” ХХК, захирал С нарын талаар олон нийтэд худал ташаа мэдээлэгдэж, түүний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэх үйл баримт нотлох баримтаар тогтоогдохгүй” гэж дүгнэн, хариуцагчийн гомдлыг хангаж, анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож, “С” ХХК-ийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

3. Нэхэмжлэгч тал нь хяналтын гомдолдоо: “...Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгуулж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээлгэх хүсэлтэй байна. Давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй, буруу тайлбарлаж хэрэглэсэн. Хариуцагч этгээд болох Э нь хэдийгээр өөрийн сонгосон арга хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлсэн боловч бусдын эрхийг хөндөх үйлдэл хийж байгаа гэдгээ мэдэж, зориуд олон нийтийг мэдээсэй гэдгийг хүсэж удаа дараагийн үйлдлээр олон нийтийн цахим сүлжээнд өөрийн захиалж хийлгэсэн тавилгын зургийг нийтэлж байснаараа хэн нэгэн этгээд тухайн захиалгат тавилгыг хийж гүйцэтгэсэн компанийн нэрийг дурдаж бичээсэй, асууж бичээсэй гэж хүлээж байсан нь тодорхой харагддаг бөгөөд энэ нь биеллээ олж “С ” ХХК-ийн нэрийг үл таних нэг иргэн асууж сэтгэгдэл бичсэн байдаг. Гэтэл хариуцагч Э ийн зүгээс өөрийн нийтлэлийн үр дагаврыг мэдэж байсан учир тухайн асуултад “мөн, биш” гэх ямар нэгэн байдлаар хариу үзүүлээгүй нь “С ” ХХК мөн шүү гэж мэдүүлж байгаа хууль бус үйл баримт юм. Энэхүү үйл баримтыг давж заалдах шатны шүүхээс “хариуцагч нь өөрийн нийтэлсэн мэдээлэлдээ компанийн нэрийг цохон тэмдэглээгүй байгаа нь хариуцагчийг хууль зөрчиж бусдын нэр төрд халдсан гэж үзэх үндэслэл болохгүй” гэж дүгнэсэн нь хуулийг зөрүүтэй, буруу тайлбарлаж хэрэглэсэн гэж үзэх үндэслэлтэй төдийгүй хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой, энэ төрлийн хууль бусаар бусдын эрхийг бүдүүлгээр зөрчих явдлыг

таслан зогсоох ач холбогдолтой юм” гэжээ.

4. Хяналтын шатны шүүхээс Хариуцагч Э- ийн фейсбүүкт 2023.08.10 гэсэн огноо бүхий Зураг гэсэн цэс рүү ороход 8 гэрэл зураг нь гал тогооны тавилгын зураг, үүдний шкаф, гал тогооны тавилга угсарч байгаа зураг бүхий 8 зураг, текст дээр энэ бүр арай юу гэсэн нэртэй мөн өдрийн өрөөний шкаф, тавилга бүхий зурагтай текст буцаагдсан нэг тавилгаа бол өгөөгүй мөнгөнд авчихсан, өөрсдийн алдаагаа мэдээд гэсэн утгатай 7 зураг, үүдний шкафын 7 зурагт уул нь их гоё харагдах байдалд хууртаж болохгүй чадахгүй бол бусдын хайран цагийг бүү үр гэсэн гарчигтай пост, манай тавилга хийлгэсэн компаниар үйлчилгээ аваад сэтгэл ханамжаар хохироосон тавилгаа солиулсан айл зөндөө байдаг байна ш дээ. Нээрээ яагаад хэлдэггүй юм болоо бүгд хөдөлмөрлөж мөнгө олдог биздээ. Гэр дотор хэмжээ аваад хүссэн чулуун тавцан манайх л далийлгаж хараад байгаа байх гээд зураг орууллаа. Хэлээд өгөөрэй гал тогооны чулуун тавцангийн 1 зураг бүхий пост, захирал нь ирээд ядаж хийсэн тавилгаа үзээсэй. Манайд байгаад байхаар эдэлгээний гэмтэл надад атаархсандаа албаар үйлдэл ийм болголоо гэхүүдээ, манайх нээрээ энэ тавилгад нь хүрч чадахгүй хэцүү байна. Хоёр бага насны хөдөлгөөн ихтэй хүүхэдтэй, юм нь салаад унах вий дээ гэхээс айгаад байна. Энд тэнд тайлбар хийж чат бичиж баримт цуглуулж хандалт тоолж байхаар манайд ирээрэй. Манайд ирээд яагаад бухимдаад байгааг нүдээр хараад гэрч болох хүн байвал хүрээд ирээрэй. Нээлттэй шүү гэх пост, хийсэн тавилганынх нь 8 зурагтай пост, мөн түүнчлэн 2023.08.19-ний өдөр “Хүнд ийм юм хийж өгчхөөд яаж хоол хоолойгоор нь даваад байж байдаг байна аа, хүн чанар гэж алга аа” гэж олон нийтэд хандан өөрийн фейсбүүкт пост /мэдээлэл/ оруулсныг 22 хүн үзэж, 34 сөрөг сэтгэгдэл бичигдэж, уг мэдээллийг 6 удаа бусдад хуваалцсан ба 34 сөрөг сэтгэгдлийн дотор ... фейсбүүк хаягаас “ene tavilga hiilgesen gazar C bilv” гэсэн болох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хийсэн үзлэгээр тогтоогдсон байх бөгөөд хариуцагч нь өөрийн фейсбүүк цахим хуудсаар нэхэмжлэгч ”С” ХХК-д тавилга хийлгэх захиалга өгсөн, хийсэн тавилга нь чанар муу байсан тул хурдан хугацаанд засвар, үйлчилгээ хийлгэх зорилгоор мэдээлэл тавьсан талаар маргаагүй байна.

5. Facebook /фейсбүүк/ нь хувь хүмүүс өөрийгөө олон нийтэд танилцуулах, санал сэтгэгдлээ хуваалцах эсвэл албан байгууллагууд бизнесээ танилцуулах, сурталчлах, мөн түүнчлэн тодорхой сонирхлын бүлгүүд хувийн болоод хамтын сонирхлоо бусадтайгаа хуваалцах, хэлэлцэхэд ашигладаг дэлхийн хамгийн том нийгмийн сүлжээ юм.Энэхүү сошиал платформ нь фейсбүүк хэрэглэгчийн илгээсэн аливаа мэдээллийг өргөн хүрээнд, богино хугацаанд, хил хязгааргүйгээр бусдад хүргэх олон давуу талтай, нөгөө талаасаа бизнес эрхлэгчдийн тухайд өөрийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг сурталчлах, хэрэглэгчдийг өөртөө татах маркетингийн шинэ суваг болсон байх бөгөөд “Фейсбүүк хуудас” нь тухайн хаяг эзэмшигч хүний хувийн зүйл мэт боловч энд оруулсан аливаа мэдээлэл нь олон нийтэд ил болдог.

6. Иргэний нэр, нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүргийг Иргэний хуулиар тусгайлан зохицуулсан.

7. Нэхэмжлэгч тал буюу ажил гүйцэтгэх гэрээний гүйцэтгэгч тал нь захиалагч буюу хариуцагчийн тавьсан шаардлагын дагуу зарим тавилгыг буцаан авч зохих төлбөрийг өгсөн, улмаар үлдсэн тавилгын доголдлыг арилгахаар гэрээний талуудын хооронд тодорхой үйлдлүүд хийгдэж байсан байх тул Э-ийн өөрийн фейсбүүк хуудаст хэд хэдэн удаа /энэ тогтоолын 7-д заасан/ пост оруулсныг бодит байдалд нийцээгүй мэдээлэл буюу нэхэмжлэгч компанийн ажил хэргийн нэр хүндэд халдсан гэж үзэх нь Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3[6]-т нийцэж байх тул анхан шатны шүүхийн хийсэн дүгнэлт, шийдвэрийг үндэслэлтэй гэж үзлээ.

8. Анхан шатны шүүхийн шийдэл зөв боловч шийдвэрийн тогтоох хэсэгт хариуцагчийн няцаалт хийх үүргийг тодорхой тусгаагүй байна. Иймээс хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулав.

9. Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3, 497 дугаар зүйлийн 497.1, 511 дүгээр зүйлийн 511.1-д зааснаар тавилга захиалж хийлгэсэнтэй холбоотой нэхэмжлэгч “С” ХХК-ийн ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тараасандаа хариуцагч Э нь өөрийн “Э” гэсэн фейсбүүк хуудсаар дамжуулан “С” ХХК-аас уучлалт гуйх, тавьсан пост бүртээ залруулга хийхийг хариуцагч Э-д даалгасугай” гэж өөрчилж, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн төлөөлөгч болон өмгөөлөгч нарын хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэжээ.

Энэхүү шийдвэрээс үзвэл хяналтын шатны шүүх “нэхэмжлэгч “С” ХХК-ийн ажил хэргийн нэр хүндийг гутаасан **мэдээлэл** тараасандаа хариуцагч Э нь өөрийн “Э” гэсэн фейсбүүк хуудсаар дамжуулан “С” ХХК-аас уучлалт гуйх” гэж тодотгож дүгнэжээ. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “…худал мэдээлэл тараасан”, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “….мэдээ …” хэмээн хуулчилжээ. Улсын дээд шүүхээс мэдээ болон мэдээллийн ялгааг заагийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тайлбарлан эрүүгийн болон иргэний хуулиар хэрхэн ялгаатай шийдвэрлэгдэх талаар тодорхой тайлбарлаагүй байна. Үүний улмаас практикт иргэний хуулиар шийдвэрлэж буй маргаанд худал ташаа мэдээлэл тараасан, мэдээ тараасан гэх аль аль агуулгаар хэргийг шийдвэрлэж байна. Түүнчлэн эрүүгийн хуулиар мөн адил мэдээ, мэдээлэл гэх агуулгын баримтлан шүүх хэргийг шийдвэрлэж ял шийтгэл оногдуулж байна.

Гэтэл онолын болон хэл зүйн хувьд “**мэдээ**”, “**мэдээлэл**” ялгаатай ойлголт юм. Энэ талаар аль ч шүүх шийдвэртэй тайлбарлаагүй, Улсын дээд шүүх хүртэл энэ 2 үгийн утга агуулгыг нэг утга агуулгатай мэтээр тайлбар хяналт тогтоол гаргаж буй учир дутагдалтай байж гэж үзэхээр байна.